



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

*2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр, Пүрэв гараг*

|  |        |
|--|--------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>   | 1      |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>        | 2 - 8  |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | 9 - 50 |

---

|  |         |
|--|---------|
| <i>1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.09.25-ны өдөр ирүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>   | 18 - 39 |
| <i>2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/</i> | 39 - 40 |
| <i>3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>   | 40 - 42 |
| <i>4. Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал</i>  | 42 - 50 |

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
11 дүгээр сарын 23-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 16 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Б.Баттөмөр, Э.Батшугар, Б.Баярсайхан, Б.Бейсен, Х.Болорчулуун, Д.Ганбат, Г.Дамдинням, Б.Жавхлан, Г.Занданшатар, Г.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж, Д.Өнөрболор, Б.Саранчимэг, Н.Учрал, Н.Энхболд, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, Ц.Мөнх-Оргил, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Сүхбаатар;

Тасалсан: Ц.Идэрбат, Ш.Раднаасэд;

Хоцорсон: Ц.Анандбазар – 06 минут, С.Батболд – 58 минут, Ж.Батсуурь – 15 минут, Х.Булгантуяа – 19 минут, Н.Ганибал – 1 цаг 07 минут, Т.Доржханд – 16 минут, Ц.Сэргэлэн – 35 минут, Ц.Туваан – 20 минут, Г.Тэмүүлэн – 2 цаг 10 минут.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Н.Алтанхуяг, Ш.Адьяа, Д.Цогтбаатар нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Н.Алтанхуяг, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хуулийн төслийг татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо. /10:39/

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсад шинэ цагийн бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 83 жилийн түүхэн ой тохиож байгаатай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс улсын бүртгэлийн байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад баярын мэнд хүргэв.

*Нэг. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.09.25-ны өдөр ирүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Б.Мажигсүрэн, мөн газрын референт Г.Нямсүрэн, мөн Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Т.Доржханд, Ш.Адъяаа, Ц.Туваан, Б.Дэлгэрсайхан нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн нар хариулж, тайлбар хийв.

*“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Мөнхбаатар:** 1.Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.Доор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

1/Орон сууцын ипотекийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэн авах хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэх;

2/Орон сууцын ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэгш, хүртээмжтэй хуваарилах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 21  
Бүгд: 41  
48.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 18  
Бүгд: 39  
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.Доор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

1/Орон сууцын ипотекийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэн авах хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэх;

2/Орон сууцын ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэгш, хүртээмжтэй хуваарилах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 18  
Бүгд: 39  
53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж дууслаа.

**Л.Мөнхбаатар:** “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 18  
Бүгд: 39  
53.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 11 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулна.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

**Л.Мөнхбаатар:** “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 19  
Бүгд: 40  
52.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 11 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай тул хуулийн төслийг Байнгын хороонд буцаах гэсэн горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 22 |
| Татгалзсан: | 17 |
| Бүгд:       | 39 |

56.4 хувийн саналаар горимын санал дэмжигдэж хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд буцаахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.*

### ***Дөрөв.Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нар танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлтүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

**Л.Мөнхбаатар:** Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Бямбасүрэнгийн Энх-Амгаланг улируулан сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 16  
Бүгд: 40  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Пүрэв-Очирын Анужинг улируулан сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 16  
Бүгд: 42  
61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Төсвийн байнгын хорооны даргаар Ганзоригийн Тэмүүлэнг улируулан сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 13  
Бүгд: 42  
69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргаар Гочоогийн Ганболдыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 13  
Бүгд: 42  
69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Эдийн засгийн байнгын хорооны даргаар Цэдэндамбын Цэрэнпунцагийг улируулан сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 13  
Бүгд: 42  
69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

---



Байнгын хорооны даргаар сонгох саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцлоо. /алх цохив/

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар “Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /12:12/

*Уг асуудлыг 12 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын урилгаар Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн харьяа ерөнхий боловсролын сургуулийн 11-ийн Б ангийн багш, сурагчид, Баянхонгор аймгийн Социал демократ Монгол залуучуудын холбооны гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Ганбаатар, С.Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 22 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын удирдлагаар Баянзүрх дүүргийн 25 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Нийслэлийн 297 дугаар цэцэрлэгийн багш, ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Д.Сарангэрэл, Т.Доржханд нарын урилгаар Хан-Уул дүүргийн ахмадуудын төлөөлөл, “Алдарт эх” цахим нэгдлийн одонтой ээжүүдийн төлөөлөл, Монгол, Солонгосын Политехникийн коллежийн багш, оюутнуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир гишүүний урилгаар Налайх дүүргийн “Эрүүл, идэвхтэй амьдрал” клубийн гишүүд Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 1 цаг 58 минут үргэлжилж, 72 гишүүнээс 47 гишүүн хүрэлцэн ирж, 65.3 хувийн ирцтэйгээр 12 цаг 14 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 16 минут.

### **НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн амрыг эрье. Ирц хүрсэн байна.

Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя.

**Нэг.** “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Монголбанк 2023 оны 9 сарын 25-ны өдөр ирүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг хийгдэнэ. Зарчмын зөрүүтэй нэг саналтай.

**Хоёр.** “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсруулсан. Эцсийн хэлэлцүүлэг хийгдэнэ.

**Гурав.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

**Дөрөв.** Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17.00 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн, Норовын Алтанхуяг, Ширнэнбаньдийн Адьшаа, Дамдины Цогтбаатар нараас албан бичгээр ирүүлсэн байна.

Үүнийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа,

2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх зөвшөөрөл олгоно уу.

Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн гэсэн байна.

Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа,

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн

чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх зөвшөөрөл өгнө үү.

Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг гэсэн байна.

Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа,

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх хүсэлтээ хүргүүлж байна.

Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбандийн Ш.Адьяа гэсэн байна.

Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх хүсэлтээ хүргүүлж байна.

Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар гэсэн байна.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн үг хэлье.

**Ц.Даваасүрэн:** Баярлалаа. Та бүгдийн энэ өглөөний амгаланг эрье.

Сүүлийн үед өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулаад хөдөөгийн иргэдийн зүгээс гишүүддээ хандсан

өвөлжилттэй холбогдолтой тодорхой арга хэмжээ авч өгөөч гэсэн ийм зүйл нэлээн яригдаж байна.

Ялангуяа өвөлжилт хүндэрсэн сумдад малаа нэлээн олон тоогоор нядалж байгаа юм байна. Нядалсан малынх нь махны үнэ уначихсан.

Дээр нь арьс шир нь үнэгүй болчихсон.

Тэгээд дайвар бүтээгдэхүүнүүдийг нь худалдаж авах хүнгүй болчихсон гээд. Ингээд орлогын нөхцөл байдал хүндэрч байна гэсэн ийм зүйлийг ярьж байгаа юм.

Тэгэхээр өнгөрсөн Засгийн газрын хуралдаанаас Засгийн газар дээр энэ өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулаад судалгаа, дүгнэлт хийх, тэгээд энэ сумдын чиглэлээр авах арга арга хэмжээний талаар тодорхой саналаа бэлтгэж оруулж ирээч гээд онцгой байдлын асуудал эрхэлсэн Шадар сайдад чиглэл өгчихсөн байгаа.

Тэгэхээр ирэх долоо хоногт Засгийн газрын хуралдаанд энэ хүндэрсэн сумд өвөлжилтийн нөхцөл байдал цаашдаа хүндрэх төлөвтэй газруудын талаар Засгийн газарт оруулж ирэх байх.

Тэгэхдээ үүнтэй холбогдуулаад Их Хурлын зүгээс тодорхой чиглэл Засгийн газарт өгчихмөөр байгаа юм. Тэгэхгүй ингээд юм болоод өнгөрсөн хойно нь манайхан чинь нэг сүр дар болох юм байна шүү дээ. Одоо энэ хүүхдийн асуудал гээд л, цэргийн асуудал гээд л.

Тэгэхээр хэдүүлээ урьдчилаад. Ерөнхийдөө өвөлжилтийн нөхцөл байдал хүндрэх нь тодорхой болчихсон учраас Их Хурал Засгийн газар хамтраад ер нь

нэг урьдчилсан тодорхой арга хэмжээнүүдийг авах шаардлагатай болсон байна л гэж бодоод байгаа юм.

Тийм учраас Засгийн газар энэ асуудлыг хэлэлцэх гэж байхад Их Хурлын зүгээс болж өгвөл маргаашийн хуралдаанаар ч юм уу энэ асуудлыг хэлэлцээд, ярилцаад тодорхой чиглэлүүд гаргачихмаар байна.

Одоо энэ арьс, ширийг нь яах юм, махны асуудлыг яах юм. Энэ гадагшаа гараад байгаа өвс тэжээлийн экспортыг нь хаах чиглэлээр арга хэмжээ авах юм уу. Эсвэл нэг удаа малын хөлийн татвар дээр нь тодорхой хөнгөлөлт үзүүлээд энэ өвөлжилтийнхөө бэлтгэлийг хангахад нь дэмжлэг үзүүлэх юм уу.

Ийм асуудлуудаар Их Хурал тодорхой чиглэл гаргачихмаар байна.

Ялангуяа Их Хуралтай холбогдолтой татвар, хураамж, энэ чиглэлтэй холбоотой зүйлүүдээр нь яах вэ гээд.

Ер нь иргэдийн зүгээс бухимдаж байгаа юм бол та нар ингээд ярьсан зүйл чинь хэрэгжихгүй байна гэдэг л юм яриад байгаа юм.

Одоо ирэх 6 сард бид ахиад л ёстой гялалзуулаад өгнө. Та нар юу хүсэж байна гээд л гүйгээд очиж болохгүй шүү дээ.

Тийм учраас үүнээс өмнө, ялангуяа энэ өвлийг даван туулахад нь тодорхой арга хэмжээ авч өгсөн байж уулзах нүүртэй болно шүү дээ.

Тийм учраас өвөлжилт хүндрэх нь тодорхой болчихоод байгаа энэ цаг үед хэдүүлээ Их Хурлын зүгээс ялангуяа бүр

санаачилга гаргаад тодорхой арга хэмжээнүүдийг авчихмаар байна.

Тэгээд Засгийн газар ирэх долоо хоногт хуралдахдаа тэр чиглэлтэй нь хамтруулаад бодлогын дагуух нь арга хэмжээнүүдээ төлөвлөөд явчихад зүйтэй юм болов уу гэж.

Бухимдах нь арга байхгүй. Махны үйлдвэр гээд л 3 махны үйлдвэр Хятадын хөнгөлөлттэй зээл гээд л хэдэн жил ярив. Арьс, ширний үйлдвэрүүд хэдэн жил ярив.

Гэтэл арьс, шир нь үнэд орохгүй, малын түүхий эд нь үнэд орохгүй. Тэгээд ийм юмнуудаа хүртэл бас нэг эргэж хараад түргэвчлүүлэх.

Хэрвээ санхүү хөрөнгийн асуудал шийдэх шаардлагатай түүн дээр нь ямар арга хэмжээ авч өгөх юм гэсэн ийм зүйлүүдээ ер нь бас нэг яриад тэгээд энэ өвөлжилтийн хүндрэл болзошгүй нөхцөл байдлыг хэрхэн даван туулах талаар ярилцвал яасан юм бэ?

Тэгээд Засгийн газар ч гэсэн бас тодорхой асуудлууд шаардлагатай бол эргэж оруулж ирье.

Ирэх долоо хоногийн гурав дахид Засгийн газарт ер нь Шадар сайд энэ өвөлжилт хүндэрсэн сумдын асуудлыг оруулж ирэх байх.

Түүнээс өмнө Их Хурал бас тодорхой чиглэлийг гаргачихмаар байна. Болохгүй бол холбогдох Байнгын хороо нь ч юм уу хуралдаад. Нэг ийм ийм арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүл гэсэн чиглэлээ Засгийн газарт өгөөд ингээд явбал яасан юм бэ.

Ер нь өнгөрсөн хойно нь хэдүүлээ хашхираад нэмэргүй шүү дээ.

Тийм учраас одоо яг малчдаа яах юм. Малаа нядлахаар бол нядлуулахыг нь нядлуулаад тэгээд тэрийг нь нөөцөд худалдаж авахаар бол худалдаж авах шийдвэрээ гаргаад ингээд тэдэндээ бас нэг ойлгомжтой нөхцөл байдлыг үүсгэж өгөх хэрэгтэй байгаа юм л даа. Тодорхой урьдчилсан арга хэмжээг малчид ч гэсэн.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Одоо Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг үг хэлье.

**Н.Алтанхуяг:** Өглөөний амгаланг айлтгая.

Би хоёр асуудал ярих юм. Ер нь байнга л ярина гэж бодож байгаа.

**Нэгдүгээрт нь,** утааны асуудал. Цаг үеийн асуудал гамшгийн хэмжээнд тун удахгүй очлоо. Одоо ч бараг гамшгийн хэмжээнд байна.

**Хоёр дахь нь,** төсөв батлаад мартаад хаячхаж болохгүй ээ. Би түүн дээр бас юмаа хэлье.

Тэгэхээр утаан дээр ийм байна. Маргааш О.Цогтгэрэл гишүүний асуултад энэ танхимд 2 цагаас утааны талаар ярилцах юм байна гэж би ойлгосон.

Тэгээд түүн дээр би бэх бүх гишүүдийг уриалж байна. Та нар маань нэг жаахан идэвхтэй оролцоод, энэ өвөл ер нь утааны байдал ер нь ямар байх юм, ямар түлш түлэх гээд байгаа юм, яг яаж шийдээд байгаа юм. Ерөөсөө оньсого тааж байна шүү дээ.

Ард түмэн байтугай би оньсого таагаад байгаа юм чинь. Тэгээд би яах вэ, уг нь ийм асуулга бэлдсэн юм. 18 асуулттай. Тэгээд үүний хариу иртэл сар гаруй болох юм байна л даа.

Тэгэхээр маргааш хэдүүлээ тал талаасаа анхаарал тавиад, ядаж энэ өвөл ер нь ямар түлш түлэх гээд байгаа юм, энэ айл өрхүүд яах юм, бид энэ үр хүүхдүүдээ яах юм, хөдөө гадаа гаргах юм уу, амралтыг нь уртасгах юм уу, яах юм уу, түлш гэж юм байна уу, байхгүй юу, хагас кокс юм уу, мидлинг юм уу, ингээд бүтэн түмэн асуулт байна. Үүнийг нэг тийш нь шийдье гэж.

Энэ хагас кокс дээр би нэг үг хэлье.

Монголын энэ төрийн гэх юм уу, эсвэл энэ намын бодлогууд их тийм алдаатай явж ирэх юм даа.

Хамгийн анх Ч.Хүрэлбаатар яг сууж байгаад хэдэн онд байна даа. 2008 оны үед хагас кокс гэдэг юмаар л утааг шийдэх юм байна гэдэг их зөв шийдлийг С.Батболдын Засгийн газар гаргасан байдаг юм.

Зөв шийдэл гаргасан мөртлөө тэрийг дампууруулах ажиллагаанд нь бас Ч.Хүрэлбаатар оролцсон гэмтэй л дээ. 17 тэрбум төгрөг ч байхгүй, хагас кокс ч байхгүй, 2012 оны 9 сарын 30-нд хүлээлгэж өгөх ёстой үйлдвэр ингээд ороогүй.

2012 оны 9 сар гэдэг чинь 11 жил ингээд түлшгүй. Завсар нь тэгээд бид янз бүрээр шийдэх гэж янз бүрийн Засгийн газрууд оролдож үзсэн.

Энэ Ц.Даваасүрэн гишүүн та Эрчим хүчний сайд байл уу, яалаа. Энэ

Ч.Хүрэлбаатар Эрчим хүчний сайд байхдаа гаргасан шийдвэрийн тухай би ярьж байна.

Ер нь хэдүүлээ ингээд олон юм бодохгүйгээр дэлхий даяараа хагас коксоор шийдчихсэн юм чинь хагас коксоо л хиймээр байх юм.

Энэ өвөл ерөөсөө чадахгүй бол, хийж амжихгүй бол гадаадаас хагас кокс аваад энэ жил утаа ядаж хоёр дахин буурна шүү дээ.

Үүнийгээ та нар тэр бүлэг дээрээ яриад шийдчихээч ээ гэж хэлэх гэж байна.

Одоо туршилт хийнэ гээд яриад байх юм. Хагас коксоор иргэд дээр туршилт хийдэггүй юм. Дэлхий өөрөө туршаад хийчихсэн юм. Үүнийг хэлэх гэсэн юм.

Төсөв дээр би нэг юм хэлье. Намайг үг хэлэхээр хойноос үг хэлээд гутаагаад болж өгөхгүй юм.

Төсөв чинь муу төсөв болсон гэдгийг би дахин хэлье.

Тэгэхдээ Н.Алтанхуяг хэлээгүй. Дэлхийн банканд ажиллаж байсан Б.Түвшинтулга гэдэг докторын ярьсан яриа миний энэ инстаграм дээр байгаа юм. Уншаарай. Одоо би тэрийг энд дахин хэлээд яах вэ.

Түүн дээр зүгээр ганцхан тоо хэлж байгаа юм. Манай Монгол Улс өнөөдөр төсвөө маш үрэлгэн зарцуулж байна. Дэлхийн 137 орноос 124 дүгээрт явж байна. Одоо ичээч. Дэлхийгээс. Ичих нүүр ч байхгүй болсон юм шиг байгаа юм.

Тэгчхээд гоё төсөв баталсан гээд.

Энэ төсөв баталчхаад хойноос нь 2024 оны төсвийн хууль батлагдсантай холбогдуулаад боловсрол, эрүүл мэндийн салбарт тэгнэ тэгнэ. Ийм юм бас байдаггүй юм.

Та бүхэн нээрээ энэ хуулийг хууль болгож үгүй мөн их завхрал хийж байна. Үүнийгээ засаж залруулаач ээ.

Тэгээд яах вэ маргаашдаа хэдүүлээ тэр нэг нүүрсэн дээр нэг анхаарал тавиад, бүгдээрээ утаан дээрээ нэг анхаарал тавиад энэ олон түмний хүсэж байгаа, ядаж мэдье гэж хүсэж байгаа асуудал дээр нь Та бүхэн маань нэг сайн асуулт, хариулт тавиад юм хийгээд өгөөч ээ.

Би Улсын Их Хурал дээр дахиад Тогтворжуулалтын сан, төсөв. Нэг нь юу билээ. Ирээдүйн өв сангийн талаар асуулга тавьчихсан байгаа.

Одоо Улсын Их Хурал дээр асуулга тавьж л өмнө нь яасан яасан гэдгийг яриулахгүй бол энэ Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар гэж хоёр худалчтай болсон. Ардын намынхан. Хүн үг хэлэнгүүт хойноосоо худлаа юм хэлээд л хаачихдаг.

Тийм учраас энэ асуулгыг би хавар хүртэл тасралтгүй тавина. Үнэн мөний эрэлд явна. Хүнийг гүтгэж болохгүй. Улсын Их Хурал дээр худлаа мэдээлэл хийж болохгүй.

Үүнийг таслан зогсоох ганцхан арга байдаг юм байна гэж би ойлгосон. Тэр нь асуулга тавих юм байна. Холбогдох хүмүүс нь орж ирээд ард иргэдэд нээлттэй юм яаж явсан, юу болсон, хаана нь яасан, Ирээдүйн өв санг хэзээ.../минут дуусав/



**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулья.

Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатарын урилгаар Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн харьяа ерөнхий боловсролын сургуулийн 11-ийн Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүүхдүүд Та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн үг хэлье.

**Ш.Адьшаа:** Баярлалаа. Миний хэлэх гэсэн санаа, хэлэх гэсэн асуудлаар Ц.Даваасүрэн гишүүн, Н.Алтанхуяг гишүүн хоёр сая хэлчихсэн учраас би нэрээ татаж авч байна.

**Л.Мөнхбаатар:** Одоо Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар үг хэлье.

**Д.Цогтбаатар:** Гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе.

Би нэг зүйлийг Их Хурлын даргын анхааралд хүргэмээр байна.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбогдуулаад нэлээн олон хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсон. Тэр дотроо Эрүүл мэндийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гээд сая манай Хууль зүйн байнгын хороондээр уржигдрын хурал дээр нэлээн олон. Нийт 120-иод

хуулиас 38 хууль дээр нь манай Байнгын хороо даруй ажиллаад нэмэлт, өөрчлөлт оруулах юмнуудыг хийж өгсөн.

Тэгэхээр энэ цахим технологийн асуудал. Манай Байнгын хороон дээр үүнийг хэлэлцсэн. Үлдсэн 80-аад хууль нь өөр Байнгын хороод дээр явж байгаа юм билээ.

Их Хурлын дэд дарга анхаарал хандуулж, бусад Байнгын хороодын ажиллагааг түргэхэн явуулж энэ асуудлыг хэлэлцэж эхлэхгүй бол. Жишээлбэл, өнөөдрийн хуралд энэ асуудал орж ирээгүй байна. Маргаашийн хуралд орж ирээгүй байна.

Гэтэл амьдрал энэ цахим технологийн асуудлыг чинь хүлээхгүй байна. Иргэд маш олон материалуудаа цахим хэлбэрээр, өөрийнхөө хүсэлтийг, гомдлыг, өргөдлийг, нотлох баримтыг гаргаад өгөх гэхээр тэр байгууллагууд чинь газар дээрээ хүлээж авахгүй байгаа юм.

Амьдрал бидний шийдвэр гаргалтын удаашралтыг хүлээхгүй хамгийн бодит жишээ сая төрийн тэргүүн дээр гарч байна шүү дээ. **Fake news**[хуурамч мэдээ].

Fake news-ийн цаана ямар ч Монгол иргэн дээр ийм **“fake news”** хийчих эрсдэл байгаад байна. 3 сая хүнд энэ эрсдэл байгаад байгаа байхгүй юу.

Тэгтэл энэ дээр юу гэх юм. Төрийн албан дээр очоод ямар нэгэн асуудлаар асуудал тавих гэхээр байгууллагууд нь бодит биет материал, эсвэл цаасаар материал авчир гэх нь байна шүү дээ.

Тэгтэл энэ бол жишээлбэл зөвхөн цахим хэлбэрээр байгаа байхгүй юу. Өөр хэлбэрээр өгөх ч боломжгүй.

Тэгээд үүнийг чинь өнөөдөр иргэдийн эрх ашиг хохирох хэлбэрээрээ үргэлжлээд байна гэдгийг бид анхаарч үзмээр байна.

Ялангуяа саяын гарч байгаа юм дээр нэг зүйлийг анхааруулмаар байна.

Би нэлээн дээр үеэс, 2020 онд би хийж байсан судалгаануудаасаа. Миний утсан дээр байж байгаа юм.

Аваад үзэхэд **“deepfake”**<sup>1</sup> гэдэг бол үнэхээр том асуудал болоод гараад ирчихсэн.

Энэ **“deepfake”**-ээр гол хэрэглэж байгаа систем нь **generative adversarial network (GAN)** гээд бүр ингээд fake news-ийг хийхдээ алдаа бодит байдалтайгаа нэг минутын дотор хэдэн мянган удаа давтаж байгаад яг оригинал юм руугаа гаргаж ирдэг бөгөөд ялгахын аргагүй болгож гаргаж ирдэг системийг энэ **GAN** буюу **generative adversarial network system** гээд байгаа юм.

Үүнийг хэрэглэж иргэдийн эсрэг янз бүрийн үйлдэл хийж болзошгүй байна шүү дээ.

Төрийн тэргүүн дээр бүр том эрсдэл үүсэж байгаа. Би төрийн тэргүүн дээр гарч байгаа эрсдэлийг манайхан бодож үзээсэй гэж бодож байгаа юм.

Жишээлбэл, Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч Б.Обамагийн эсрэг

нэлээн хэдэн жилийн өмнө fake news гарсан.

Тэр fake news дээр ерөөсөө Цагаан ордон халдлагад өртлөө. Б.Обама Ерөнхийлөгч хөнгөн шархадсан гэдэг мэдээ гарахад 6 минутын дараа тусгай албад нь энэ мэдээг байхгүй болгоод, мэдээг тогтворжуулахад Америкийн зах зээл дээр **S&P 500** [Standard and Poor's stock reports] компаниудын хувьцааны үнэ доргиод, компанийн үнэлгээн дээр өөрчлөлт гарахад **136.0 тэрбум доллар**ын алдагдал гарчихсан байсан.

Монгол Улсын эдийн засгийг 7, 8 дахин давсан алдагдал 6 минутын дотор гарч байгаа юм.

Тэгэхээр ийм том эрсдэл ард нь байж байгаа шүү.

Ийм эрсдэл байгаад байхад манайх хууль тогтоох процесс маань аль болох хурдан явж үүнийгээ анхаарч ажилламаар байгаа юм.

Манай Байнгын хороо цаг алдахгүй бид орж ирсэн бүх асуудлыг маш яаралтай шийдэж өгөөд явж байгаа шүү. Тэгээд энэ дээр анхаарч өгөөрэй гэж хэлмээр байгаа юм. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн олон аймагт өвөлжилтийн байдал хүндэрч байгаатай холбогдуулаад Улсын Их Хурал дээр тодорхой мэдээлэл сонсох, тодорхой шийдвэрүүд гаргах шаардлагатай байна гэсэн асуудлыг тавьж байна.

Өнөөдөр Улсын Их Хурлын дарга орон нутагт ажиллаж байгаа. Тэгээд сая холбогдсон. Энэ асуудлуудыг шаардлагатай бол маргаашийн чуулганы

---

<sup>1</sup> Хиймэл оюун ухаанд суурилсан дүрс эсвэл дуу хоолойг нэгтгэх арга.



нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх боломжтой гэж үзэж байна.

Тийм учраас холбогдох мэдээллийг Байнгын хороод, Их Хурлын Тамгын газрынхан энэ талаар холбогдох сайдуудынх нь мэдээллүүдийг нэгтгээд эргэж танилцуулъя. Маргааш өглөө нээн хэлэлцэх асуудал дээр ярья.

Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг Улаанбаатар хотын утаа болон сайжруулсан түлшний талаар хэлэлцэх асуулгатай холбоотой ярьсан.

Энэ чиглэлээр Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл асуулга тавьчихсан байгаа.

Үүнийг маргаашийн чуулганы нэгдсэн хуралдаанаар маргааш сонсоно. Энэ үед Н.Алтанхуяг гишүүний тавьж байгаа асуудлууд давхцаж байгаа. Энэ асуудлаар Улсын Их Хурал тодорхой хэлэлцүүлэг явуулна гэдгийг хэлье.

Дээр нь Н.Алтанхуяг гишүүн бас Ирээдүйн өв сантай холбоотой асуулга өөрөө тавьсан байгаа юм байна. Гэхдээ саяхан хоёр долоо хоногийн өмнө Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Батгөмөр Ирээдүйн өв сангийн талаар асуулга тавьж, тодорхой мэдээллүүдийг авсан.

Энэ дээр нэмэлт мэдээлэл шаардлагатай гэж үзэх юм бол хэлэлцэх эсэх асуудлыг даргын зөвлөл дээр ярья гэж бодож байна.

Ш.Адъяаа гишүүн асуулт давхацсан учраас нэрээ татсан байна.

Дамдины Цогтбаатар гишүүн, Хууль зүйн байнгын хороон даргын тавьж байгаа асуудал их чухал асуудал байгаа юм.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах чиглэлээр холбогдох хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулах асуудал байгаа.

Хууль зүйн байнгын хороо хэлэлцсэн. Зөвхөн Хууль зүй хэлэлцсэн. Бусад Байнгын хороогоор яаралтай хэлэлцүүлэх асуудлыг бид даргын зөвлөлөөр хэлэлцэнэ.

Энэ дээр нь Инновац, цахим бодлогын байнгын хороо үндсэн Байнгын хороо нь байгаа юм.

Тийм учраас Байнгын хороо ирэх долоо хоногт хуралдаад энэ асуудлаа оруулж ирэх ёстой гэж үзэж байна.

Тийм учраас энэ үед таны саяын ярьсан асуудлуудыг хамтад нь яриад цахим шилжилтэй холбоотой асуудлын талаар тодорхой ахиц гарна гэж үзэж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20.3-д хууль тогтоолын төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч хууль тогтоолын төслөө татан авах үндэслэлээ тусгасан албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хууль тогтоолын төслөө татан авсанд тооцно гэж заасны дагуу Засгийн газраас ирсэн албан бичгийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа,

Хуулийн төсөл татан авах тухай.

Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн **Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай** хуулийн төслийг татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна.

Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргав.

Монгол Улсын ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гэсэн байна.

Хуулийн төслийг татан авсанд тооцлоо. /алх цохив/

Зочин танилцуулья.

Баянхонгор аймгийн Социал, демократ Монгол залуучуудын холбооны гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүгдийн ажил хөдөлмөрт өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Мэндчилгээ дэвшүүлье.

Өнөөдөр Монгол Улсад шинэ цагийн бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 83 жилийн түүхэн ой тохиож байгаа тул Монгол Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс улсын бүртгэлийн байгууллагын нийт ажилтан, албан хаагчид Та бүгдэд баярын мэнд хүргэе.

Бүртгэл бол төр, иргэнийг холбосон гүүр, улсын тусгаар тогтнолын баталгаа.

Одоогоос 15 жилийн өмнө иргэний бүртгэл, эд хөрөнгийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллагуудыг нэгтгэн Улсын бүртгэлийн ерөнхий газрыг байгуулж, бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болсон.

Бүртгэлийг төгөлдөршүүлж иргэний шинэчилсэн бүртгэлийг хийх, орчин цагийн цахим иргэний үнэмлэхийг бий болгох, эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, бүртгэлийн архивын бүхий л мэдээллийг цахимжуулах, үйлчилгээний стандартыг шинээр нэвтрүүлж, иргэд байгууллагад хүрч үйлчлэх зэрэг олон ажлуудыг шат дараалалтай авч хэрэгжүүлсний үр дүнд бүртгэлийг нэг цонхоор авч чаддаг болоод байна.

Түүнчлэн орчин цагийн технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн бүртгэл бүхэлдээ цахимжаад байна.

Цахим үйлчилгээний **“Хур”**, **“Дан”** систем, **“e-mongolia”** систем нэвтэрч нэг иргэн нэг бүртгэл зорилт үндсэндээ биелээд байна.

Бүртгэлийн байгууллагын төгөлдөржилт дээр суурилан өнөө төрийн байгууллагаас иргэд, байгууллагад үзүүлэх үйлчилгээг цахимаар үзүүлж, төрийн үйлчилгээ иргэдэд шуурхай, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хүрэх боломж ийнхүү бүрдээд байна.

Та бүхний үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаад талархал илэрхийлэхийн сацуу улсын бүртгэлийн

байгууллага үүсэж хөгжсөний 83 жилийн  
ой бүртгэлийн ажилтны баярын мэндийг  
Та бүхэнд хүргэе.

Хэлэлцэх асуудалдаа орёе.

---

**Нэг. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл  
батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**  
*/Монголбанк 2023.09.25-ны өдөр ирүүлсэн,  
эцсийн хэлэлцүүлэг/*

---

“Төрөөс мөнгөний бодлогын  
талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл  
батлах тухай” Улсын Их Хурлын  
тогтоолын төслийн эцсийн  
хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт  
бэлтгэсэн талаарх Эдийн засгийн  
байнгын хорооны танилцуулгыг Улсын  
Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам  
танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

**Ч.Ундрам:** Улсын Их Хурлын  
дарга, Эрхэм гишүүд ээ,

Монголбанкнаас Төв банкны  
тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2  
дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 9  
дүгээр сарын 25-ны өдөр Улсын Их  
Хуралд ирүүлсэн “Төрөөс мөнгөний  
бодлогын талаар 2024 онд баримтлах  
үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их  
Хурлын тогтоолын төслийн анхны  
хэлэлцүүлгийг 2023 оны 11 дүгээр сарын  
16-ны өдрийн чуулганы нэгдсэн  
хуралдаанаар явуулж, төслийг эцсийн  
хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн  
засгийн байнгын хороонд шилжүүлсэн  
билээ.

Тус Байнгын хороо тогтоолын  
төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн  
тухай асуудлыг 2023 оны 11 дүгээр сарын  
22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд

чуулганы нэгдсэн хуралдааны анхны  
хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын  
дэмжлэг авсан саналуудыг тогтоолын  
төсөлд нэмж тусган, төслийн агуулга,  
зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг,  
дэс дарааллыг жигдлэх хууль зүйн  
техникийн засваруудыг хийсэн болно.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар  
төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах  
үед хуралдаан даргалагчаас зарчмын  
зөрүүтэй нэг саналын томъёоллыг санал  
хураалгахгүйгээр гүйцээн боловсруулах  
чиглэл өгч Байнгын хороонд  
шилжүүлснийг Монгол Улсын Их  
Хурлын чуулганы хуралдааны дэгийн  
тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д  
заасныг баримтлан санал хураалт  
явуулахад хуралдаанд оролцсон  
гишүүдийн олонх дэмжлээ.

Нэгдсэн хуралдааны анхны  
хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан  
зарчмын зөрүүтэй саналуудыг тогтоолын  
төсөлд нэмж тусгасан эцсийн хувилбарын  
төсөл болон эцсийн хэлэлцүүлгийн үеэр  
санал хураалгахаар нээлттэй үлдээсэн  
зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг  
Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд  
ээ,

“Төрөөс мөнгөний бодлогын  
талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл  
батлах тухай” Улсын Их Хурлын

тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Ч.Ундрам гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн, Монголбанкны дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван, Монголбанкны Ерөнхий эдийн засагч Доожавын Ган-Очир, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Баярсайханы Баярдаваа нар оролцож байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Ш.Адьяаа гишүүнээр тасаллаа.

Одоо Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Энэ удаагийн Төрөөс баримтлах мөнгөний бодлого дээр бас нэг заалтыг нэлээд тодорхой тусгаж өгсөн нь онцлог байгаа.

Энэ нь юу юм гэхээр өнөөдөр хот хөдөөгүй ер нь хамгийн их эрэлт

хэрэгцээтэй байгаа зүйл ипотекийн зээл буюу орон сууцын зээл байгаа.

Тэгээд үүнийг өмнөх жилүүдийн төсөв хэлэлцэх үед ч, мөнгөний бодлого хэлэлцэх үед ч Засгийн газар нь ч юм шиг, Монголбанк ч юм шиг. Мэдээж манайтай хамтран ажилладаг олон улсын байгууллагуудаас энэ бол Төв банк дээр байх ёсгүй, Засгийн газар өөрөө үүнийгээ авах ёстой гээд л Засгийн газар луу шилжүүлж өөр нэгжтэй больё гээд л үүнийг нэлээд зогсонги байдалд оруулсан.

Гэтэл эрэлт, хэрэгцээ ипотекийн зээл дээр маш их байгаа.

Тэгээд энд өмнө нь орон нутагт орон сууцжуулах ажилд оролцож байгаа аж ахуйн нэгжүүд юм уу, ипотекийн зээлийг 60, 40 хувиар шийдье. Өөрөөр хэлбэл 60 хувь нь хөдөө орон нутагт, 40 хувь хотод гэдэг. Энэ байж боломгүй зүйлээ. Тоо тогтоож болохгүй гээд миний бие болон бусад гишүүд үүний эсрэг хатуу зогссон.

Одоо харин энэ заалт нэлээд чамбайраад ямар ч байсан ипотекийн зээлийг тэгш, хүртээмжтэй эрэлт, хэрэгцээн дээр үндэслэж олгох асуудал орж ирээд Засгийн газарт шилжих хүртлээ Монголбанк ипотекийн зээлийг хариуцахаар энэ мөнгөний бодлого дээр заалт оруулж өгч байна. Энэ өөрөө маш чухал.

Тэгээд Эдийн засгийн байнгын хороон дээр бид асуулт хариултаас харж байхад ямар ч байсан Төв банк дээр одоогийн зээл авсан хүмүүсийн буцаан төлөлтөөс 500 тэрбум төгрөг, арилжааны банкнуудад 100 тэрбум. Ямар ч байсан

600 орчим тэрбум төгрөгийг ипотекийн зээл рүү гаргах бололцоо байгаа гэж хэлж байна.

Одоо харин эрэлт, хэрэгцээ ийм их байгаа үед ялангуяа гэр хорооллыг орон сууцжуулах асуудал хууль орж ирээд энэ нь нэлээд сайн явж байна.

Нийслэл Улаанбаатар хот өнөөдөр түгжрэлийн тухай, утааны тухай ярьж байна. Гадаа утаа ямар байна. Тийм ээ. Хоржуу чанар нь хүртэл асар их нэмэгдсэн.

Бид үүнийг нэг зуухаар солиод юу ч өөрчлөгдөхгүй. Сая зуух шинэчлэх гээд л орж ирж байна. Ингэж мөнгө үрэхийн оронд зүгээр л ипотекийн зээл гаргаад л иргэдийг хашаанд нь хаус бариад амьдруулах, эсвэл орон сууцжуулах. Энэ бол шийдэл. Тэгэхгүй бол түлш нь ямар байна. Улам л хортой болоод байна. Бодит байдлыг бид одоо бодитоор харах ёстой.

Тийм учраас ипотекийн зээл рүү гаргах хөрөнгийг 600 тэрбум гэдэг хангалтгүй. Бид үүнийг нэлээд ахиухан нэмэгдүүлэх хэрэгтэй байгаа.

Тийм учраас гэр хорооллыг орон сууцжуулахад ялангуяа эртээд 50, 50 гээд ирц байхгүй үед уг нь 20 орчим хувийг нь энэ гэр хороолол руу иргэдэд олгох дээр анхаарал хандуулъя гээд орж байсан боловч энэ заалт уначихсан.

Тэгээд ямар ч байсан Монголбанкнаас би яг энэ асуултаараа бид ипотекийн зээл дээр өчигдрийн заалт дээр аль болохоор тэгш байдлыг хангаж олгоно гэхчхэн байгаа. Гэхдээ яаж олгох вэ?

Та бүхэн маань хэлж байсан. Өмнөх жилүүдээс харахад одоо бид хөдөө орон нутагт түгжрэл бууруулах үүднээс хөдөө орон нутагт олгох орон сууцын зээлийн хувь хэмжээг нэмэх тухай ярьж байсан боловч Та бүхэн маань яг судалгаа аваад үзэхэд хөдөө орон нутагт барьж байгаа орон сууц нь бага, дээрээс нь хүсэлт өгдөг нь цөөхөн байдаг.

Тийм учраас 70 хувь нь Улаанбаатар хотод олгогдож байсан гээд.

Одоо тэгэхээр Та бүхэнд ирж байгаа судалгаагаар нийслэл Улаанбаатар хот, орон нутагт ер нь ипотекийн зээлийн эрэлт, хэрэгцээ хэр өндөр байна? Та бүхний одоо яг төлөвлөж байгаа олгогдох 600 орчим тэрбум төгрөг үүний хэдэн хувьд нь л хүрэх ийм хэмжээний санхүүжилт вэ? Энэ дээр би хариулт авъя гэж бодож байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулья.

Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг, Жамбалын Ганбаатар, Салдангийн Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 22 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс ажил хөдөлмөрт нь амжилт, сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе. /алга ташив/

М.Оюунчимэг гишүүний асуултад хэн хариулах вэ? Монголбанкны

Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн хариулъя. Ажлын хэсгийн 83 дугаар микрофон өгье.

**Б.Лхагвасүрэн:** М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Тийм. Би зүгээр статистик тоо хасуулсан гэж ойлгоод. 2023 оны 11 сарын 17-ны өдрийн байдлаар нийт банкны системийн иргэдээс хүлээж авсан өргөдөл нь 17 мянган зээлийн хүсэлт. Мөнгөн дүнгээр нь тооцох юм бол 1.7 их наядын эрэлт ирчихсэн байгаа.

2023 оны эхнээс нийтдээ 676.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй их хөтөлбөрийн зээлийг 6.5 мянган өрхөд олгоод явж байна.

Амины орон сууцтай холбоотой асуудал дээр нэг стандарттай холбоотой асуудал байгаа юм. Гэр хороололд орон сууц барихад мэдээж нэгдүгээрт таны гишүүний хэлж байгаа тэр утаанаас байгаль орчинд ээлтэй байхаар. Гол нь хөрсний бохирдолтой холбоотой гэдгээрээ дэд бүтэц байх ёстой.

Дэд бүтцээс гадна баригдаж байгаа байшин нь ипотекийн зээл 30 жилийн хугацаатай урт хугацаатай зээлд хамрагдахын тулд түүнд нь барилгын хийц, стандарт нь хэр нийцэж байна гэдгээрээ стандартын тийм нөхцөл тавих зайлшгүй шаардлагатай болж байна. Тийм.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах уу? Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

**М.Оюунчимэг:** Бид энэ утааны асуудлыг төр бодлогоор л шийднэ.

Одоо бид сайжруулсан түлш, зуух шинэчлэх нэрээр сүүлийн 20 жил хэдэн тэрбум их наяд төгрөгийг салхинд хийсгэлээ шүү дээ. Нэг хэсэг хүний кармааг л зузаатгасан болохоос биш утаа буураагүй. Гэр хороололд нэг ч айл иргэд байшинд орох бололцоо хаалттай байсан.

Тийм учраас бид төсөв мөнгөний бодлогыг уялдуулаад аль болохоор айл өрхийг орон сууцжуулах асуудал руу л маш том бодлогын арга хэмжээ авах хэрэгтэй байгаа.

Тийм учраас Төв банкныхан мөнгөний бодлого дээр **“Ногоон зээл”** гээд явж байгаа. Тийм ээ. “Ногоон зээл” гэж байна. **“Ипотекийн зээл”** гээд явж байна.

Тэгэхээр үүнийг яг тэр хэрэгцээтэй хүмүүст нь олгох. Олгохдоо дэндүү өндөр шалгууртай байгаа учраас яг авах хэрэгцээтэй байгаа хүмүүс нь энэ зээлд хамрагдаж чадахгүй байгаа юм. Ногоон зээл жишээлбэл.

Тийм учраас бүгдээрээ иргэдийнхээ тэр орлого энэ тэрийг судалж үзэж байгаад яг тэр эзэнд нь энэ зээлийг хүргэх, хүргэхдээ шалгуур энэ тэрийг нь бодолцож үзэх маш чухал байгаа шүү.

**Л.Мөнхбаатар:** Санал хэллээ. Тийм ээ.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд асуулгаа асууя.

**Т.Доржханд:** Баярлалаа. Би ажлын хэсгийн гишүүн юм. Тэгэхдээ нэг зүйлийг тодорхой хэлэхгүй бол болохгүй байна.

Тэр нь юу байна гэхээр “**мөнгөний бодлого**”-д ирэх жил орон зай байхгүй шүү. Яагаад гэхээр Монгол Улсын төсөв 27.1 их наядаар батлагдчихсан.

Яагаад гэхээр зах зээл дээр асар их хэмжээний мөнгө тараагдана. Тэр мөнгө хэзээ тараагдах юм? Оны эхэнд тараагдана шүү дээ. Сонгуулиас өмнө.

Тэгэхээр инфляцын хүлээлт маш өндөр байна. Бодит байдал дээр.

Манай эдийн засагчид байдаг. Монголын эдийн засгийн клуб гээд 3 мянга гаруй эдийн засагчид байдаг юм. Монголд байдаг хамгийн шилдэг эдийн засагчид байдаг. Макро эдийн засагчид байдаг.

Ерөнхий төсөөллөөр төсвийг 1 их наядаар тэлэх юм бол инфляцын өсөлт 1 хувиар дээшээ харвана гэдэг. Ийм байгаа.

Тэгээд үүнээс харах юм бол бид ирэх жилийн инфляц 15 хувьтай байх юм байна гэдэг ерөнхий төсөөлөл байгаа шүү.

Тэгээд нэг гараараа бид цалинг 10 хувь өсгөлөө гэхэд гараараа инфляцыг 15 хувь өсгөчихөөр таны карманд байгаа 100 төгрөг чинь 110 төгрөг болоод цалин өссөн боловчиг нөгөө талдаа худалдан авах чадвар чинь 15-аар хасагдаад 95 болчихоод байгаа байхгүй юу. Үүнийг эдийн засагч “**чөтгөрийн тойрог**” гээд байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол зарлага санхүүжилтийг өсгөхөөр яадаг вэ гэхээр мөнгөний бодлогын хүү хатуурдаг,

зээлийн хүү өсдөг. Үр дүнд нь бизнесүүд ширгэдэг. Тэгээд үр дүнд нь юу болж байна гэхээр юмны үнэ өссөнөөс болоод иргэдийн худалдан авах чадвар саардаг.

Эцсийн эцэст хувийн сектор агшдаг. Тэгээд төсөв, төрийн худалдан авалт, эсвэл төрийн өмчийн компанийн туслан гүйцэтгэгчээр ажиллах ийм л сонголт үлддэг.

Бид 33 жил ингэж явлаа. Энэ жил ч гэсэн яг ийм л хүлээлттэй байгаа шүү гэдгийг цохон тэмдэглэчихмээр байна. Нэг.

Ажлын хэсэг хуралдаж байхад би нэг зүйлийг тэмдэглэмээр байна.

Ажлын хэсгийн ахлагч Ч.Ундрам маш сайн ажилласан.

Тухайлбал, “**ипотекийн зээл**”-ийг нэмэлт эх үүсвэрээр санхүүжүүлэх асуудал яригдаж байсан. Үүнийг таслан зогсоосон.

Өөрөөр хэлэх юм бол өмнө нь эргэлдэж байгаа **эргэлтийн сангаас** нь энэ **эх үүсвэрийг гаргана** гэдэг энэ зохицуулалт орж ирж байгаагаараа маш сайн шүү.

Өөрөөр хэлбэл ямар нэгэн мөнгө хэвлэхгүй, ямар нэгэн нэмэлт эх үүсвэр гаргахгүй, сонгууль дугтсан популизм байхгүй. Тэгээд үүнийг ажлын хэсэг дээрээ хийж чадсан нь зөв.

Харин өнөөдөр орж ирж байгаа хоёр дахь асуудал байгаа. Орон сууцын ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл, орон



нутагт тэгш, хүртээмжтэй хуваарилах гээд.

Тэгээд энэ дээр би Байнгын хороон дээр ч гэсэн, ажлын хэсэг дээр ч гэсэн эсрэг байр суурьтай байгаа.

Тэгээд өөрөөр хэлэх юм бол энэ заалтыг аваад хаячхаач л гээд байгаа юм.

Бид чинь зах зээлийн эдийн засагт шилжээд 33 жил болж байгаа. Одоо ингээд бүх л юмыг нэг хуваарилах тогтолцоо руу л яваад байгаа. Монголбанкны хүмүүс бид юм хуваарилах гээд байна шүү дээ. Хуваарилах гээд байна шүү дээ. Тэгш хүртээмжтэй. Бүгд нь хүртээгээд хүртээгээд явчихъя гэдэг.

Үгүй ээ. Гэтэл зах зээл үүнийг шингээж авч чадах уу? Энд чинь зээл олголоо гэхэд төлбөрийн чадвар байна уу? Буцаан төлөгдөх эрсдэл нь байна уу? Зах зээл нь байна уу? Тэнд дэд бүтэц нь угсрагдсан байна уу?

Энэ бүгдээс хамаараад бид эндээсээ шууд шийдвэр гаргах нь буруу л гээд байгаа юм.

Харин бодлогын хувьд орон нутагт орон сууцжуулах хөтөлбөрийг дэмжих нь зүйтэй. Би бүх 330 сумын 80 сумдаар нь явж өөрөө харж байна. Зарим төвлөрөл үүсчихсэн газар яалт ч үгүй дэд бүтцийг нь шийдэж өгөх шаардлага байна. Энэ зээл очих шаардлагатай байна.

Тэглээ гээд үүнийг хүчээрээ тэгшхэн хуваарилна гэдэг бол зах зээлийн зарчим биш шүү.

1990 онд бид зах зээлийн эдийн засгийг бий болгоно. Хувийн сектор дээр тулгуурласан парламентын засагтай улс байна гээд тов тодорхой тусгачихсан мөртлөө дандаа үүнийхээ эсрэг үйлдэл хийгээд байгаагаа зогсооё.

Ийм болохоор энэ заалтыг бүгдээрээ аваад хаячихъя гэж санал.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн дарга нь хариулъя. Чинбатын Ундром гишүүн хариулъя.

**Ч.Ундром:** Нэгдүгээрт, ипотекийн хөтөлбөрийг үргэлжлүүлэх асуудал Монгол Улсын 2024 оны төсвийг дагалдаж гарсан Улсын Их Хурлын тогтоолд орчихсон байгаа.

Энэ тогтоолд орох орохдоо хот болон хөдөө орон нутагт тэнцвэртэй олгох гэсэн байдлаар орсон байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын тогтоолтой бид энэ үндсэн чиглэлээ уялдуулах ёстой.

Тэгэхээр бид уялдуулж үүнийг оруулсан байгаа. Заавал мөнгөний бодлогын үндсэн чиглэлд оруулж байгаа шалтгаан нь 2023 оны үндсэн чиглэлд бид ипотекийн зээлийг Засгийн газар луу шилжүүлэх ёстой гэж оруулсан байсан.

Тэгэхээр одоо бид энэ дээрээ засаад Засгийн газар шилжүүлж автал нь үүнийгээ өөрийн эх үүсвэрээс нь санхүүжүүлэх. Мөн Улсын Их Хурлаас төсвийн тухай хуулийг дагаж гарсан тогтоолтой уялдуулаад үүнийг нь орон



нутагт тэгш хүртээмжтэй хуваарилах гэж байгаа.

Тэгээд өөрийн эх үүсвэрээр нь санхүүжүүлэхэд жилд **620.0** тэрбумын боломж бид нарт байгаа гэсэн. Тэгээд Барилгын яамнаас авсан судалгааны дагуу бид эрэлтийг нь асуусан.

Тэгэхээр орон нутагт 2023 оны, одоо өнөөдрийн байдлаар **373.4** тэрбум төгрөгийн эрэлт байна. Улаанбаатар хотод нэг их наяд төгрөгийн эрэлт байна гэсэн байгаа юм.

Тэгэхээр орон нутагт энэ **620.0** тэрбум чинь тал нь хангалттай хуваарилагдахад байр, орон сууц бүх юм бэлэн байгаа.

Дээрээс нь бид хөдөөгийн сэргэлт гэдэг хөтөлбөрийг маш удаан ярьж байна. Энэ нь ипотекийн зээл, мөнгөний бодлоготойгоо ч гэсэн уялдах ёстой учраас бид Улаанбаатарт хүмүүс олноороо ирээд, амьдраад, түгжрээд байхын оронд орон нутаг руу шилжээч ээ гэдэг Засгийн газрын бодлого байгаа учраас үүнийгээ дэмжих хүрээнд Та бүхнээс санал хураалгах гэж байгаа хоёрдугаар асуудлыг оруулж байгаа юм.

Тэгэхдээ нэг санал хураалтаар нэгмөсөн явах байгаа юм шүү.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах уу? Тогмидын Доржханд гишүүн тодруулж асууя.

**Т.Доржханд:** Харин тийм.

Тэгэхээр бид зах зээл хаана байна тийшээгээ мөнгөө өгдөг ийм л систем байх ёстой биз дээ.

Тэгэхээр орон нутгийг бид дэмжье гэх юм бол болно болно. Энэ өгүүлбэрээ л оруулчихмаар байна шүү дээ. Тэгэхгүй тэгш хүртээмжтэйгээр хуваарилаад явна гэхээр манайд 33 жилийн төсвийн зовлон энд яг харагдаад байна шүү дээ. Тийм биз дээ.

33 жил бид амсуулж амсуулж явсаар байгаад сүүлийн 40 жилийн хугацаанд цахилгаан станц барьж чадсан уу? Том дэд бүтцээ санхүүжүүлж чадсан уу? Боомтоо санхүүжүүлж чадсан уу?

Ингээд 76 тийшээ тараасны үр дүнд Монгол Улс хөгжлийнхөө боломжийг алдаад байгаа нь бодитой биз дээ.

Одоо Монголбанкийг чи ипотекийн зээлийг тараагаад тараагаад гээд. Энэ төсөв юм уу? Үгүй.

Энэ ипотекийн зээлийг яаралтай Барилга, хот байгуулалтын яаманд шилжүүл л дээ.

Тэгээд зарчимд нь оруул л даа. Чадвартай хэсэг нь тэнд дэд бүтцийг нь угсарсан хэсэгт нь үүнийг түлхүү өгч болно.

Гэтэл энэ чинь эсрэгээрээ төлөгдөхгүй бол яах вэ гэдэг асуудал гарч ирнэ шүү дээ энэ чинь.

**Л.Мөнхбаатар:** Харуулах уу? Ажлын хэсгийн ахлагч Чинбатын Ундррам хариулъя.

**Ч.Ундрам:** Ер нь мэдээж Төв банк ипотекийн зээлийг санхүүжүүлээд явах ёсгүй. Зарчмын хувьд.

Тийм ч учраас бид 2023 оны мөнгөний бодлого дээр үүнийг Засгийн газарт шилжүүл гэдэг үндсэн чиглэл баталж, үүрэг өгсөн байгаа.

Монголбанкны зүгээс бэлдээд өгье гээд бүх материалаа бэлдчихээд байдаг.

Гэтэл Засгийн газар үүнийг хүлээж авах бүтцийн хувьд шийдвэр гаргаагүй өнөөдрийг хүрсэн байна л даа.

Энэ хооронд ипотекийн зээлийн эрэлт хэрэгцээ маш өндөр байгаа учраас бид яалт ч үгүй Засгийн газрыг шилжүүлж автал үүнийг Монголбанк хариуцаад хийгээд явж байна.

Гэхдээ таны түрүүн хэлсний дагуу мөнгө нэмж хэвлэхгүйгээр өөрийнх нь зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэх ёстой гэдгээрээ бид оруулж байгаа.

Өнөөдрийн хүндрэлтэй нөхцөл байдалд хамгийн боломжийн шийдвэрийг л энд оруулж өгсөн гэж үзэж байгаа.

Эрэлтийн хувьд эрэлт нь байгаа юм. Хөдөө орон нутаг.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулья.

Улсын Их Хурлын гишүүн Батгөмөрийн Энхбаярын удирдлагаар Баянзүрх дүүргийн 25 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил

хөдөлмөрт нь амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн асуултаа асууя.

**Ш.Адьяа:** Өнөөдөр Улсын Их Хурал төрөөс баримтлах мөнгөний бодлогын тухай асуудлыг хэлэлцэж байна.

Би 4 жилийн хугацаанд нэг л асуудал асуудаг.

Монгол Улс уул уурхайн олон арван тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн экспортолдог тухай мэдээг бид авч, ийм олон тэрбум долларын экспорт хийсэн тухай ярьдаг.

Гэтэл Монгол Улсын банк, санхүүгийн байгууллагаар Оюу Толгой, бусад томоохон уул уурхайн компаниудын гадаадад гаргаж байгаа алт, зэс, бусад бүтээгдэхүүний үнэ ханш ерөөсөө Монголын банкаар орж ирдэггүй.

Энэ оруулж ирэхийг хүсдэггүй юм уу, оруулж ирэх боломж байдаггүй юм уу гэдэг талаар тодорхой хариулт өгдөггүй юм.

Монгол Улсын банк, санхүүгийн байгууллагаар оруулж ирэх гэхээр Монголын банканд итгэдэггүй гэдэг.

Тэгэхээр гадаадын банк оруулж ирэх асуудлыг ярьдаг.

Гэтэл гадаадын банкиг оруулж ирэх гэхээр Монгол Улсын банк, санхүүгийн байгууллагыг хувьдаа эзэмшдэг улс төрд нөлөө бүхий хэдхэн

арилжааны банкны барьцаанд Монголын төр орсон байдаг.

Тэгээд эд нар юу гэдэг вэ гэхээр үндэсний аюулгүй байдалд хор нөлөөтэй байна. Гаднын банкиг оруулж ирэхээр Монгол Улсын үндэсний аюул байдалд аюул занал учрах гээд байна гэдэг ганцхан хариулттай.

Тэрийг нь төрийн эрх барих дээд байгууллага ярьж шийддэггүй. Тэгээд банкны хүү буурдаггүй.

Монголын валютын эх үүсвэр болсон тэр уул уурхайн бүтээгдэхүүнийг чинь Монголын банк, санхүүгийн байгууллагаар дамжиж оруулах асуудлыг арилжааны банкуудын лоббигаар оруулж ирдэггүй гэж ойлгож байгаа. Энэ асуудлыг яах юм?

Ажлын хэсэг, Монголбанкны удирдлагууд энд нэг тодорхой хариулт өгмөөр байна.

Үнэхээр бид төгрөгийн ханшаа барья, валютын эх үүсвэрээ нэмэгдүүлбэ, Монголын банк, санхүүгээр дамжуулж гадаадад гаргадаг уул уурхайн бүтээгдэхүүнийхээ мөнгийг авья гэж бодож байвал Монголын төр шийдвэр гаргах ёстой.

Бид өнөөдөр хэдхэн тооны арилжааны банкны барьцаанд орчихсон. Тэд нар нь өнөөдөр мөнгө хүүлээд ард түмнийг мөлжиж л байдаг. Монголын банк санхүүгийн байгууллага эрүүл бус байж л байдаг. Олон арван сая тонныг нь алт, зэс зарлаа гэдэг. Тэр мөнгө нь орж ирдэггүй. Цаасан дээр л бид өнөөдөр мэдээлэл гаргаад байна шүү дээ.

Энэ дээр төрийн эрх барих дээд байгууллага, мөнгөний бодлогыг явуулдаг Монголбанк яагаад энд шийдвэр гаргадаггүй юм бэ?

Би сүүлийн гурван удаагийн мөнгөний бодлогыг ярихад одоо шийдэх гэж байгаа, тэгж байгаа, удахгүй гаднын банкиг оруулж ирнэ. Ингээд л хууль эрх зүйн орчин гээд зөндөө юм ярьдаг.

Тэгээд ингээд байсаар байх юм уу? Цаашлаад худлаа үндэсний аюулгүй байдлын асуудал гээд л тэр арилжааны хэдэн банканд барьцаалагдсан улс төрчид, улс төрийн хамаарал бүхий хүмүүсийн энэ асуудал чинь байгаад байх юм уу? Тэгээд Монголын банк санхүүгийн байгууллага гаднын зарсан уул уурхайнхаа бүтээгдэхүүнийг авах чадваргүй гэдэг энэ асуудлаа нотолсоор байх юм уу? Яаж бид өнөөдөр төгрөгийн ханшийг, мөнгөний бодлогыг барих юм бэ? Энд нэг хариулт авмаар байна.

**Л.Мөнхбаатар:** Эдийн засгийн байнгын хорооны дарга хариулъя. Дараа нь ажлын хэсгийн ахлагч нэмж хариулъя.

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулъя.

**Ц.Цэрэнпунцаг:** Ш.Адъяаа гишүүний асуултад хариулъя.

Ш.Адъяаа гишүүн ээ, бид ноднин Хөрөнгө оруулалтынхаа банкны хуулийг баталчихсан шүү дээ. Одоо хүчин төгөлдөр байгаа. Эрх зүйн орчин хангалттай. Хуультай болчихсон.

Энэ гаднын хөрөнгө оруулагчид мэдээж хууль, эрх зүйн орчин бүрэлдсэн гээд шууд ороод ирэхгүй байна.

Дээрээс нь Хөрөнгө оруулалтын хууль. Ер нь Монгол оронд хөрөнгө оруулалт хийхэд гадаадын хөрөнгө оруулагчид ямар байх юм. Энэ хөрөнгө оруулалтын орчноо судалж тандаж байгаа. Энэ нь цаг хугацаа авч байгаа асуудал байгаа байх.

Тэгэхээр яг таны саяын ярьсан Их Хурлаас анхаарал хандуулах ёстой гэж байгаа энэ ажлаа Их Хурал хийчихсэн.

Энэ асуудал дээр одоо бид Их Хурлын хувьд ажлаа хийсэн. Ганцхан Монголбанкныхан гаднын хөрөнгө оруулагч гадаадын банкныхантай уулзалтууд хийж байгаа. Хуулиа танилцуулж байгаа.

Ер нь Хонг Конгийн гэхэд л Хонг Конгод байгаа хоёр, гурван банк Монголбанкттай уулзалт хийх, манай бизнесийн орчин, хөрөнгө оруулалтын орчныг судалж анхаарч байгаа асуудлууд байгаа.

Тэнд байгаа консул идэвхтэй сайн ажиллаж байгаа. Ийм асуудлууд явсан.

Мөн бид Банкны хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тийм ээ. Банкны хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ хууль бид хэрэгжих хугацааг жоохон шахуу тавьсан. Бас бодит амьдрал дээр нийцэхгүй тал байгаа. Бид энэ дээр цаг хугацааны хувьд банкныхаа хуулийн хэрэгжилтийг тодорхой сунгах шаардлага гарч ирэх, цаг хугацааны хувьд ийм нөхцөл байдал үүсчхээд байгаа.

Банкны хуулиар бид банкныхаа хөрөнгө оруулагчдыг хэт төвлөрсөн

байдлыг задлах, олон хөрөнгө оруулагчтай болох.

Мөн IPO гаргаж олон нийтэд хувьцаагаа гаргасан. Бүх банкууд. Та мэдэж байгаа. Системийн 5 том гол банк олон нийтэд хувьцаагаа гаргаж, хөрөнгийн бирж дээр арилжаалсан нээлттэй компаниуд болж байгаа.

Тэгээд энэ чиглэлд хангалттай бид эрх зүйн орчныг нь бүрдүүлээд үүнийхээ дагуу банкууд олон нийтэд нээлттэй болоод явж байгаа.

Тэгэхдээ хамгийн том хувьцаа эзэмшигч 20 хувиас илүү төвлөрөл үүсгэж болохгүй гэсэн Банкны хуулийн дагуу хамгийн цөөхөндөө 5 хөрөнгө оруулагчтай болох ёстой.

Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын хувьд бас л бид гадаадын том хөрөнгө оруулагчид орж ирж банкны хувьцаа эзэмшихгүй бол дотооддоо бид том хувьцаа авах, ялангуяа том банкуудын хувьцаа авах хөрөнгө оруулагч цөөхөн байгаа учраас хуулийн хэрэгжилт дээр цаг хугацааны хувьд жоохон тулмагдчихсан явж байгаа асуудал бий. Түүнээс бусад асуудлаар таны ярьсан шиг ийм.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Хариулт хангалттай юу? Нэмэх юм уу?

Ажлын хэсгийн ахлагч нь нэмээд хариулчихъя. Чинбатын Ундрэм.

**Ч.Ундрэм:** Гадаадын банк орж ирэх эрх зүйн орчин нь бэлэн байгаа гээд сая Ц.Цэрэнпунцаг дарга хэлж байна.

Тэгээд анх удаа бид Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлдээ гадаадын банкны бие даасан салбар нэгжийг оруулж ирэх гээд бүр заагаад өгчихсөн. Анх удаа.

Тэгэхээр энэ ингээд үүрэг болоод Монголбанкн дээр ажил болоод очиж байгаа. Энэ үүргээ биелүүлэхийн тулд Монголбанкны зүгээс нэлээн идэвхтэй ажиллана. Тэрийгээ ч гэсэн банкны зүгээс илэрхийлж байгаа.

Мөн Төв банкнаас гадаадын банкнийг оруулж ирээд ажиллуулах журмууд боловсрогдоод явж байгаа гэж яригдаж байгаа.

Уул уурхайн компаниудын экспортын бүтээгдэхүүнтэй холбоотой мөнгө төгрөгийн хувьд Монголбанкнаас өгсөн мэдээллийн дагуу 2022 онд байх аа, Оюу Толгой компани 1.6 тэрбум ам.доллар дотоодын зах зээл рүү оруулж ирсэн. Экспортын орлого 1.4 тэрбум байсан гэсэн ийм мэдээлэл байгаа.

Гадаадын уул уурхайн компанитай холбоотой нэмэлт мэдээллийг Төв банкны зүгээс нэмж өгөх шаардлагатай гэж бодож байна.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах уу? Ширнэнбаньдын Ш.Адьяаа гишүүн тодруулж асууя.

**Ш.Адьяаа:** Тэр гаднын банкнуудыг оруулж ирэх хууль эрх зүйн орчин бүрдүүлсэн, уул уурхайн компаниуд экспортын бүтээгдэхүүний төлбөрийг Монголын банк, санхүүгийн байгууллагаар дамжуулж авах энэ хууль

эрх зүйн орчныг бүрдүүлсэн гэдэгтэй санал нэг байгаа. Ойлгож байгаа.

Гэтэл өнөөдөр энэ хуулийг ноднин бид батлаад өнөөдөр ингээд явахад нэг ч юм ахиц гарахгүй байгаа гэсэн ойлголттой л байгаа.

Ер нь тэр Оюу Толгой гээд компани Монголын төр засгийг, Монголын банк, санхүүгийн байгууллагыг үл тоодог асуудал өргүүлсээр байгаа гэж ойлгож байгаа.

Яагаад гэхээр өнөөдөр олон улсын банк, санхүүгийн шалгуур болсон нээлттэй хувьцаат компани нь Монголын банкууд болсон шүү дээ. Тодорхой 20 хувь хүртэл.

Гэтэл яагаад өнөөдөр Монголын банк, санхүүгийн байгууллагаар энэ мөнгө төгрөг нь орж ирэхгүй. Энэ дээр Монголбанк, Улсын Их Хурал, Засгийн газар энд шахаж шаардаж.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад хариулъя. Хэн хариулах вэ? Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн хариулъя. Ажлын хэсгийн 83 дугаар микрофон өгье.

**Б.Лхагвасүрэн:** Ш.Адьяаа гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийдөө тодруулж хариулъя. Ц.Цэрэнпунцаг гишүүн, Ч.Ундрам гишүүн хууль эрх зүйн орчин, тэр бодлогуудын талаар товч дурдчихлаа.

Тэгээд угаасаа энэ ажил хэрэгжээд явж байгаа. Зүгээр би Ш.Адьяаа гишүүнд тоонууд хэлэх гэсэн юм.

Уул уурхайн орлого, ялангуяа Монголын экспортын бүтээгдэхүүний 93 хувь нь уул уурхайн бүтээгдэхүүн байдаг гэдэг утгаараа экспорт энэ онд эхний 3 улирлын байдлаар **12.5** тэрбум долларт хүрсэн. Өмнөх жилээс өндөр өсөлттэй явж байгаа.

Энэ утгаараа Монгол Улсын валютын нөөц нэмэгдэж байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын валютын нөөц **1.4** тэрбум доллар болсон. Гуравхан долоо хоногийн өмнө Монгол Улсын Засгийн газар Хөгжлийн банкны **350.0** сая доллар төлөгдсөн хэдий ч өнөөдөр нөөц өөрөө **4** тэрбум доллартой тогтвортой хэвийн байж чадаж байгаа.

Ханш ерөнхийдөө өнгөрсөн оны яг мөн үетэй харьцуулахад бараг хөдөлгөөнгүй байгаа. Оны эхэн.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Яах юм? Гүйцээх юм уу? Болчихсон юм уу? Асуултдаа тодорхой хариулт авлаа.

Зочин танилцуулья.

Нийслэлийн 297 дугаар цэцэрлэгийн багш, ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс ажил хөдөлмөрт нь өндөр амжилт сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо Цэвэгдоржийн Ц.Туваан гишүүн асуултаа асууя.

**Ц.Туваан:** 2024 оны мөнгөний бодлого хэлэлцээд эцсийн хэлэлцүүлэг рүү орж байна.

Тэгээд энэ дээр хэлэх нэг санал байна. Тодруулж асуух нэг зүйл байна.

Хөдөө орон нутгаар явахаар иргэд маш их бухимдалтай байна. Юунд бухимдалтай байна гэхээр ерөөсөө малаа нядлаад борлуулъя гэхээр авдаг хүн байхгүй болчхож. Мөнгө байхгүй.

Тэгээд л ямар нэгэн байдлаар тариаланчид тариа будаагаа, ногоочид ногоогоо, хадланчид хадлан тэжээлээ борлуулъя гэхээр дан бартер ярьж байна.

Эдийн засгийн чинь гол явуулж байдаг мөнгөний урсгал чинь ерөөсөө байхгүй. Мөнгө гэдэг юм ерөөсөө нүхэндээ ороод алга болчхож.

Тэгэхээр Монголбанкныхан байгаа дээр энэ “**бодлогын хүү**” гэдэг юмаа ингэж өндөрсгөөд, зээл царцаагаад, тэгээд мөнгө явахгүй, хөдлөхгүй байгаа. Энэ хүмүүс чинь юугаар жоохон бүтээсэн зүйлээ борлуулж, юугаар хэрэгцээгээ хангах мөнгөө хаанаас олж авах юм бэ?

Тэгэхээр юу гэж асуугаад байна вэ гэхээр бодлогын хүүгээ ер нь хэзээ, яаж бууруулах юм бэ?

Одоо энэ чинь ямар нөхцөл байгаад байгаа юм бэ? КОВИД байхгүй. Монгол улс өнөөдөртөө дайн тулаан алга.

Тэгээд энэ хөдөө орон нутагт байгаа ажиллаж, амьдарч байгаа иргэд

чинь мөнгөгүйдлээ шийдэхийн тулд зээлээр л явж байна шүү дээ.

Одоо зарим аймагт чинь, ялангуяа зүүн тал руу бид хэд чинь ер нь зээр, зээл хоёроор амьдарч байна шүү дээ гээд л ярьж байна шүү дээ. Тэгээд зээл яах вэ, дандаа өндөр хүүтэй. Нэг үеэ зээлийн хүүг овоо хөөцөлдөөд бууруулаад ирж байсан. Одоо зээлийн хүү буцаад өндөр болчихсон. Олдохоо больчихсон. Банкнаас зээл гаргахаа больчихсон. Одоо банк бусуудын зээл бараг юугаа даахгүй байгаа байх.

Дээрээс нь аппликэйшны зээл гэдэг юманд орчихсон. Одоо тэр покет ч билүү, өөр юу юу ч билээ. Аппликэйшнээр мөнгө зээлээд авч байгаа.

Тэгэхээр Монголбанкн дээр мөнгөний бодлого барьж байгаа аппликэйшны зээлд ер нь хэдэн төгрөг эргэлдэж байна аа? Та хэдэд тоо байна уу?

Надад хүмүүс хэлсэн. 2.9 их наяд гэсэн тоо хэлж байгаа. Түүний хэмжээ, хүүг хэлээдхээч та хэд. Мөнгөний бодлого барьж байгаа л юм бол. Нэг ийм асуудал байна шүү.

Хоёрдугаарт, ипотека.

Яах вэ, Засгийн газар авахгүйгээр би дэмжиж байгаа. Чадахгүй. Нэг яам аваад тэрийг ажиллуулж чадахгүй. Монголбанк одоохондоо туршлагатай. Аваад явж байсан нь зөв.

Тэгээд энэ дээр мөнгө чинь та хэд 600.0 тэрбум төгрөг гээд энэ ипотекийн зээлийн хүүгийн орлогоос орж ирж

байгаа л мөнгө шүү дээ. Үүнийгээ нэг айлд байшингийн үнэ өндөр болчихсон. Нэг айлд 150.0 сая төгрөгөөр зээллээ гэж бодъё л доо.

Тэгэхэд ерөөсөө 4 мянгахан хүний хэрэгцээ. Энэ ипотекийн зээл чинь арын хаалганы авлига, хээл хахуулийн хэрэгсэл болчихоод байгаа шүү. Олдохгүй. Эрэлт байгаа учраас.

Тэгэхээр энэ дээрээ ямар нэгэн бодлого байгаа юм уу, эсвэл чихээ таглаад энэ 600-г нь л хувааж өгөөд ингэх юм уу. Энэ чинь хөдөө орон нутагт 4 мянга байлаа гэж бодоход 2 мянга, 2 мянгаар нь хуваалаа гэж бодоход 21 аймагт нэг аймагт 100 хүрэхгүй. Ерэн хэдхэн зээл. Тэгээд сумдад хуваахаар яах юм. Манай Төв аймаг шиг 27 сумтай газарт ерэн хэдийг хуваахаар нэг сумын хүн аймагт ч юм уу энд тэнд байр авъя гэхэд гуравхан л оногдох гээд байна шүү дээ. Хэмжээ үнэхээр хангалтгүй байна.

Тэгэхээр энэ дээр та хэд маань ямар бодлоготой байгаа юм бэ? Энэ дээр нэг жоохон эх үүсвэр талдаа нэг улс байна даа, улсын төв банк байна даа нэг бодлого явуулаад нэмэгдүүлчхэж болохгүй юм уу? Үнэхээр хэрэгцээ байна шүү. Энэ дээр нэг хариулаадхаач.

**Л.Мөнхбаатар:** Ц.Туваан гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Ч.Ундрэм хариулъя. Дараа нь, Эдийн засгийн байнгын хороогоор нэмж хариулъя. Чинбатын Ундрэм хараарай.

**Ч.Ундрэм:** Хоёрдугаар асуудлаас нь эхлээд хариулъя.



Нэгдүгээрт, бид хэрвээ эх үүсвэрийг нэмэгдүүлье гэвэл мөнгө хэвлэхээс өөр аргагүй болно. Тэгээд мөнгө хэвлэх юм бол эргээд инфляц чинь нэмэгдээд явна шүү дээ.

Тэгэхээр ард иргэдийн амьдрал нь илүү хэцүү болно.

Тийм учраас бид өнөөдөр эргэн төлөлтөөр нь үүнийг зохицуулъя гэж байгаа юм.

Жилд ойролцоогоор **620.0 тэрбум** төгрөгийн эргэн төлөлт цуглараад түүгээрээ эргээд ипотекийн зээл өгөх боломж бүрдэж байгаа.

Тэгээд хөдөө орон нутгийн эрэлтийг бид судалсан. Барилга, хот байгуулалтын яамнаас ирүүлсэн материал дээр 2023 оны байдлаар **334.0 тэрбум** төгрөгийн эрэлт байна гэж байгаа юм.

Тэгэхээр энэ эрэлтийг саяын **620.0 тэрбум** төгрөгийн **50 хувь чинь хөдөө орон нутагт олгогдоно** гэдэг үндсэн чиглэл батлагдах юм бол энэ эрэлтийг хангах бүрэн боломжтой байгаа юм. Энэ жилийн хувьд.

Тийм учраас бид тэнцвэртэй **620.0** тэрбум төгрөгийг хот, хөдөө тэнцвэртэй олгоно гэдэг заалтыг санал хураалгах гээд оруулж ирж байгаа юм.

Хотын эрэлтийг мэдээж нөхөж гүйцэхгүй. Төсвийн тэлсэн бодлого явж байгаа үед **мөнгө хэвлэх ямар ч боломжгүй** байгаа.

Бодлогын хүү өндөр байгаа. Цаашид бид үндсэн чиглэл дээр **инфляцыг 6-аас 8 хувийн хооронд**

**барина** гээд үндсэн чиглэлд оруулж байгаа.

Ингэхийн тулд бодлогын хүү чанга байхаас өөр ямар ч аргагүй байгаа. Энэ дээр **Монголбанк бие даасан, хараат бусаар чанга бодлогоо бариад явахаас өөр аргагүй** гэж ажлын хэсэг дээр бид үзэж байгаа.

Гэхдээ үндсэн чиглэл дээр бид **“хэрэглээний зээл”**-ийг багасгаад бизнесийн, ялангуяа ажлын байр нэмэгдүүлэх **“бизнесийн зээл”**-ийг илүү нэмээчээ гэсэн чиглэлийг оруулж өгч байгаа.

Болж өгвөл харьцааг нь 60, 40 гэсэн харьцаатайгаар **“бизнесийн зээл”**-ийг олгох байгаа.

2023 оны төсөв дээр бид **“Хүнсний хувьсгал”**-ын хүрээнд хүнсний чиглэлийн зээлийн дотацийн мөнгийг тавьж өгсөн. Үүнтэй холбоотойгоор хүнсний үйлдвэрүүд, үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд ойролцоогоор **1 их наяд төгрөг**-ийн зээл авахаар байгаа.

Одоогийн байдлаар 600, 700 тэрбум төгрөгийн зээл авчихсан.

Зээлийн хүсэлт судлагдаж байгаа. 300-аас 400 тэрбум төгрөг байгаа. Тэр нь энэ жилдээ олгогдчихно. Ингээд 1 их наяд.

2024 оны төсөвт хүүгийн татааст **125.0 тэрбум төгрөг** яг энэ хүнсний салбарт тавьсан байгаа.

Тэгэхээр энэ нь хэрэгжээд ирэх жил хүнсний салбарт бага хүүтэй зээлүүд



дахиад гарах боломж нь бүрдчихсэн байгаа.

**Л.Мөнхбаатар:** Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг нэмж хариулъя.

**Ц.Цэрэнпунцаг:** Ц.Туваан гишүүний асуусан асуултад сая ажлын хэсгийн ахлагч Ч.Ундрам гишүүн хариулчихлаа.

Нэмээд товчхон хэлэхэд **“мөнгөний бодлого”** барьж байгаа Монголбанкнаас бид бүр эсрэг хоёр шаардлагыг нэг доор хэрэгжүүл гээд л шаардаж болохгүй шүү дээ.

Энэ мөчид “эсвэл хэвт”, “эсвэл бос” гэдэг хоёр үйлдлийг зэрэг хий гэвэл боломжгүй. Тийм ээ. Эсвэл хэвтэнэ, эсвэл босох ёстой.

Тэгэхээр Монголбанк өнөөдөр энэ инфляц гэдэгтэй тэмцэхийн тулд инфляцыг өөрийн зорилтот түвшинд авчрахын тулд мөнгөний хатуу бодлого явуулахаас өөр арга байхгүй.

Тэгээд та нөгөө талдаа Монголбанкнаас дахиад та нар мөнгө хэвлэ, энэ зээлийн эх үүсвэр хангалтгүй байна, ипотекийн зээл хангалтгүй байна гэж шаардаж байгаа чинь инфляци хөөрөгдөөд 20, 30 хувь болго л гэж шаардаж байгаа асуудал.

Тэгэхээр таны шаардлага бодит амьдрал дээр хэрэгжих боломжгүй л дээ.

Тэгэхээр Монголбанк нэг юмаа л барих ёстой. Та Монголбанкнаасаа эсвэл хатуу бодлогоо бариад инфляцаа буулга, эсвэл үүнийгээ тавиад инфляц хамаа алга.

Тэр мөнгөний эх үүсвэрийг илүүгээр мөнгөө хэвлэ гэж шаардах ийм хоёр л зам байгаа.

Тэгэхээр та үүнийгээ тодорхой, Монголбанк дээр аль шаардлага тавихыг нь дараа нь тодруулаад нэг шаардлагыг нь тавьчих хэрэгтэй байх.

Хоёрт, энэ зөвхөн ипотекийн зээл. Энэ бага хүүтэй зээл чинь зөвхөн ганц эх үүсвэр биш арилжааны банкнууд дээр дахиад Банкны байр авах энэ зээлийн эх үүсвэрүүд байгаа шүү дээ. Энэ арилжааныхаа, зах зээлийнхээ хүүтэй арилжааны банкуудад олгож байгаа арилжааны банкуудаас авч болох зээл хангалттай байгаа.

Тэгэхээр зөвхөн энэ ганцхан Монголд байгаа байр авдаг зээл биш.

Тийм учраас нийт байр авч байгаа иргэдийн зээлийн нэг хэсэг нь. Тэгээд болж өгвөл бид үүнийгээ ялангуяа хөдөө орон нутагт төрийн байгууллагад ажиллаж байгаа, дээрээс нь орлого багатай иргэддээ энэ зээлийг хүргэхийн тулд, өндөр хүү төлөх боломжгүй иргэддээ аль болохоор хүргэхийн тулд энэ боломжийнхоо хэмжээгээр инфляцаа араас нь хөөргөчихгүй шиг энэ зээлийг хүргэж өгье гэж энэ бодлогоо барьж явж байгаа юм.

Тэгээд хамгийн гол нь өнөөдөр зээлийн хүүгээс орж ирж байгаа мөнгө биш л дээ. 600.0 тэрбум төгрөг чинь ипотекийнхоо зээлийн эргэн төлөлтөөс орж ирж байгаа мөнгө шүү дээ. Хүүгээс нь тодорхой хувь нь орж ирж байгаа. Монголбанкныхан тодорхой тоо баримт хэлэх байх.

Тэгэхээр үүнийгээ бид буцаагаад гаргаж байгаа нь инфляцаа хөөрөгдөхгүй л энэ хэмжээндээ. Нөгөө “хөнжлийнхөө хэрээр хөлөө жийнэ” гэдэг энэ л бодлогоо баримталж ажиллаж байгаа юм.

Тэгээд Монголбанкныхан гүйцээгээд хариулчих.

**Л.Мөнхбаатар:** Хэн хариулах вэ? Нэмээд хариулчихъя. Тийм ээ. Монголбанкнаас нэмж тодруулгад хариулт өгье.

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн хариулъя.

**Б.Лхагвасүрэн:** Ц.Туваан гишүүнд тоо баримтуудыг нь тодорхой тодотгоод хэлээд өгье гэж бодсон юм.

Эхний асуулттай холбоотой банк бусын тоо гэсэн.

Нийт банкнаас бусад банк бус санхүүгийн салбараар **3.1 их наядын** зээл олгогдсон байна. Түүний **1.6 их наяд** нь “**хэрэглээний зээл**” буюу энэ дотор аппликэйшнээр олгогдож байгаа зээл ороод явж байгаа юм.

**“Ипотекийн зээл”**-тэй холбоотой тооны хувьд 2024 онд Монголбанкны өөрийн тооцоолж төсөөлж байгаагаар нийт ипотекийн зээлийн эргэн төлөлтөөр 500-аад тэрбум төгрөг үндсэн өр болон хүүгийн төлбөрөөр хамтдаа орж ирнэ.

Ипотекийн зээл олгогдохдоо Монголбанкны эх үүсвэр **80.0 хувь**, арилжааны банкны эх үүсвэр **20.0 хувь** байдаг болохоор Монголбанкны **500.0** тэрбумын эх үүсвэр дээр

арилжааны банкны 100-аас 120 тэрбум төгрөгийн эх үүсвэр ороод явахаар нийтдээ 600-аас 620 тэрбум төгрөгийн хооронд 2024 онд ипотекийн зээл олгогдох боломжтой гэж тооцоогоо хийсэн.

**Л.Мөнхбаатар:** Та тодруулах юм уу? Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууя.

**Ц.Туваан:** Ажлын хэсгийн дарга аа, тэр тоо чинь худлаа шүү. Маш их эрэлттэй байгаа.

“Ипотекийн зээл” ховрын, арын хаалганы бараа болсон шүү гэдгийг хэлье.

**Хоёрдугаарт,** Эдийн засгийн байнгын хорооны дарга ийм байр суурьтай байгаад би харамсаж байна.

Монголбанк өөрөө Их Хурлын харьяаны байгууллага. Монгол Улсын банк юм байгаа биз дээ энэ чинь.

Монголд хэрэгцээ байхад тэрийг мөнгө хэвлэнэ үү. Хэвлэх л хэрэгтэй шүү дээ. Тусгаар улсын Төв банк юм бол мөнгө хэвлэх л хэрэгтэй шүү дээ.

Тэр инфляц дээрээ өөр бодлогоо гаргаад барь л даа. Инфляцын чинь бүтээгдэхүүн мах, гурилын үнэ, бензиний үнэ, барилгын материалын л үнэ шүү дээ.

Түүн дээрээ өөр бодлогоо хэрэгжүүлээд, энэ зээлээ чөлөөлөөд, энэ бодлогын хүүгээ бууруулаад, ипотекийн зээлийн эх үүсвэрээ нэм л дээ.

Олдохгүй байна шүү дээ. Барилгын компаниуд чинь ч гэсэн

борлуулалт нь явахгүй байна шүү дээ. Тодорхой асуудал дээр ганц.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Үг хэллээ. Саналаа хэллээ.

Зочин танилцуулья.

Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин, Даваажанцангийн Сарангэрэл, Тогмидын Доржханд нарын урилгаар Хан-Уул дүүргийн ахмадуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил амьдралд нь сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн асуултаа асууя.

**Б.Дэлгэрсайхан:** Та бүхнийхээ энэ өдрийн амрыг эрье.

Би Монголбанкныхнаас асууя гэж бодоод байгаа юм.

Экспортын орлого 12.5 тэрбумын орлоготой. Долларын. Тэгээд мөнгөний ханшаа бариад, ингээд мөнгөний бодлогоо зөв бариад явж байгаа чинь дэмжиж байгаа.

Гэхдээ хэдэн асуудлууд байна. Гишүүдийн хэлсэнтэй давхцаж байна.

Банкнүүдаас олгож байгаа зээлийн хэмжээ дэндүү бага байгаагаас болоод банк бусын зээлийн хүү дэндүү өндөр

болсон. Үүнийг та нар яаж хянаж байгаа юм бэ?

Үнэхээр хүмүүс зайлшгүй шаардлагаар банк бусаас зээл аваад зээлээс зээлийн хооронд маш их хүнд байдалтай амьдарч байна.

Тэгээд банкууд чинь голдуу хэрэглээний зээл олгож байгаа юм.

Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч өө. Үүнийгээ жоохон **“бизнесийн зээл”** олгох асуудал дээр нь Монголбанк ямар бодлого барих юм бэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, банкууд хөдөө орон нутагт **“ипотекийн зээл”** өгөх асуудал дээр ямар бодлого барих юм?

Ер нь тэнцвэртэй олгоё гэдэг шийд гарах гэж байна шүү дээ, ухаандаа. Тэгээд хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд чинь аль болохоор хөдөө орон нутагт хүмүүсээ төвлөрлөө сааруулья, хөдөө орон нутагт хүмүүс амьдрах боломж, бололцоог бүрдүүлье гэж ярьчихаад тэгээд хөдөө орон нутагт байшин барилга баригддаг. Ипотекийн зээл нь олддоггүй.

Тэгээд энэ хүмүүс чинь олддог газар луу нь л ирнэ шүү дээ. Ойлгомжтой шүү дээ.

Тэгээд хоёрдугаарт, та нар үүнийгээ хөдөө орон нутагт. Сая жишээлбэл би Дорноговьд 500-аад айлын орон сууц орсон юм. Зарим нь ч яах вэ түрээсийнх болоод явчихсан. 370-н хэд нь ингээд ипотекийнх.

Тэгээд хүмүүс зээлээ авна гээд гэрээгээ хийгээд очоод зээлээ авч

чадахгүй байна. Маш олон хүмүүс гомдол мэдүүлж байна.

Мөнгө байгаа гэж хошхируулчхаад тэгээд очсон хойно нь ямар нэгэн шалтаг хэлээд байлгаад байна. Үүнийгээ та нар Дорноговь руу банкууд руу руугаа яриад, асуугаад нэг тодорхой хариу өгөөч.

Хоёрдугаарт, хөдөө орон нутагт та нар 3 хувьтай өгнө гэж ярьчхаад яг амьдрал дээр 6 хувьтай өгч байна шүү дээ. Яаж байгаа юм? Тэгээд хөдөө орон нутагт барих бодлого, хүмүүсийг хөдөө рүү явахад нь дэмжинэ барина гэж өчнөөн шийдвэр, янз бүрийн юм гарчхаад одоо болохоор очсон хойноо 6 хувьтай. Үүнээс буухгүй. Тэгээд үүнийг авбал ав гэдэг.

Дээрээс нь энэ ипотекийн зээл чинь сая Ц.Тувааны хэлдэг үнэн шүү.

Банк дотроо бас нэг ийм жижигхэн мөнгөний асуудал, бас нэг жоохон жижиг шан харамж гэдэг юм уу, тийм авлигалын асуудлаар энэ ипотекийн зээл чинь шийдэгдэж байгаа юм биш биз дээ? Хүмүүс тийм юм яриад байна шүү дээ.

Чадалтай нь аваад, чадалгүй нь авч чадахгүй байна гээд байна шүү дээ.

Үүнийг чинь юу гэж ойлгох юм.

Тэгээд үүнийгээ та хэд нэг тодорхой хариулаад өгөөч ээ. Уг нь мөнгөний бодлого, валютын ханшийн юуг сайн барьж байгааг чинь дэмжиж байна. Гэхдээ үнэхээр та нар энэ ипотекийн зээл дээр анхаарахгүй бол

хөдөө орон нутагт өчнөөн хүмүүсийг дэмжинэ гээд.

Одоо тэгээд энэ бодлого чинь тэгээд яаж явах юм бэ? Хот, хөдөөгийн сэргэлт гэж зөндөө бид ярьж байгаа шүү дээ.

Тэгээд энэ төвлөрлийг сааруулах юм бол та нар энэ бодлогоо л барья л даа. Бүгдээрээ нийлж байгаад. Тэгэх үү? Нэг хариулт аваад би асууя. Дараа нь.

**Л.Мөнхбаатар:** Б.Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулъя. Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн хариулъя.

**Б.Лхагвасүрэн:** Б.Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийдөө нийт банкны системийн олгож байгаа зээлийн өсөлт жилийн туршдаа 15.4 хувь. Энэ дотроо тэр хэрэглээний зээл дийлэнх хувийг нь эзлээд нэлээн өндөр хувьтай явж байгаа.

Монголбанкны зүгээс хэрэглээний зээлийг багасгаж, илүү **бизнесийн** зээл гаргах талаар бодлогын өөртөө байдаг бодлогын арга хэрэгслүүдийг аваад хэрэгжүүлээд явж байгаа.

Ерөнхийдөө дэлхий нийтийн дундаж стандарт байдаг. Өр, орлогын харьцаа гэдэг.

Ямар хэмжээний орлоготой байна түүнийхээ 70 хувиар л хэрэглээний зээлд хамрагдах стандарт байдаг.

Үүнийг Монголбанкны хувьд бид хэрэглээний зээлийг багасгах үүднээсээ 60, 40 болгосон.

Тэгэхээр нэлээн хатууруулж байна гэсэн үг. Энэ утгаараа ер нь банкны салбараас харилцагч нар банк бус руу шилжиж байгаа хөдөлгөөн гарч байгаа. Тэр утгаараа банк бусын салбар дээр хэрэглээний зээл ер нь нэлээн өндөр өсөөд явж байгаа.

Нэгэнт мөнгөний хатуу бодлого явуулж байгаа гэдэг утгаараа бодлогын хүү 13 гээд өндөр. Тэгээд зээлийн дундаж хүү ерөнхийдөө 18 хувь гээд дундаж хүү 18, 19, ингээд 20 хувьтай ингээд зээлүүд олгогдож явж байгаа нь мэдээж нэлээн хатуу нөхцөл байгаа.

Тэгэхдээ бид аль болохоор хэрэглээний зээлийн багасах тал руугаа бодлогоо чангалаад явж байгаа.

Ипотекийн зээлтэй холбоотойгоор зүгээр би хамгийн сүүлийн долоо хоног бүрээр бид статистик тоогоо гаргаад явж байгаа.

2023 оны 11 сарын 13-наас 17-ны хооронд энэ долоо хоногт хэр хэмжээний зээл гарсан бэ гэхээр зүгээр яг Дорноговь аймаг гэдгээр орон нутгийг жишээ болгоод авахад энэ долоо хоногт 19 зээл гарсан байна. Нийт зээлийн дүн нь 1.7 тэрбум.

Оны эхнээс хойш 2023 оны туршдаа Дорноговь аймагт 95 зээл. Зээлийн дүн нь 6.3 тэрбум гэдгээр явж байгаа.

Ерөнхийдөө Их Хурлаас Улаанбаатар болон орон нутгаараа тэнцвэртэй, хүртээмжтэй хэлбэрээр олгохоор зорилго явж байгаа гэдэг

утгаараа Монголбанкнаас банкуудтай энэ талаар чиглэлийг өгөөд явж байгаа.

Аль болохоор орон нутаг руу түлхүү өгөхөөр анхаараарай гэдгээрээ.

Тэгээд сүүлийн долоо хоногт нийт Монгол Улсын хэмжээгээр 206 зээл гарсны 105 нь Улаанбаатар хотод, 101 нь орон нутагт гарсан байгаа ийм тоо ирсэн. Тийм. Сүүлийн долоо хоног.

**Л.Мөнхбаатар:** Тодруулж асууя. Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн асууя.

**Б.Дэлгэрсайхан:** Дахиад нэг асуух юм байна.

Манай Эдийн засгийн байнгын хороо Санхүүгийн хороогоо дуудаж авчраад үүнийгээ анхаарахгүй юм уу?

Бид чинь банк бус санхүүгийн байгууллагыг хөхиүлэн дэмждэг бодлого явуулж байна шүү дээ.

Энд байгаа хэдэн хулгайч нар л гээд загнуулаад балбуулаад байдаг. Гадуур чинь ер нь нэг банк бустай хүн болгон л баяжиж байна. Тэр баяжих нь ч яах вэ. Зах зээлийн л хууль байх.

Тэгэхдээ энэ чинь төрийн, бид нарын хийх ёстой ажил биз дээ. Нэг талдаа хүмүүсийг ядууруулж байгаа шүү дээ. Ийм зэрлэг хүүгээр.

Тэгээд яах юм бэ энэ чинь. Тэгээд хүмүүс ажил хийх сонирхолгүй болчихлоо шүү дээ. Мөнгөтэй хэсэг нь ерөөсөө бүтээлч биш зүгээр мөнгө саадаг.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Санал хэллээ. Тийм ээ. Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулъя. Товчхон хариулчихъя.

**Ц.Цэрэнпунцаг:** Манай Санхүүгийн зохицуулах хорооноос энд байна уу? Ажлын хэсэг дээр байхгүй байгаа. Тийм ээ.

Санхүүгийн зохицуулах хороонд Б.Дэлгэрсайхан сайд та энэ асуудлаа албан ёсоор хандаад. Тэгээд бид энэ дээр танд тодорхой хариу Байнгын хорооноос өгье.

**Л.Мөнхбаатар:** Яах юм? Нэмж хариулах гэж байгаа юм уу? Тийм ээ. Тодорхой хариулт өгөх үү? Чинбатын Ундрам ажлын хэсгийн ахлагч нэмж хариулъя. 1 минутад багтаагаад хариулъя.

**Ч.Ундрам:** Уг нь бид нарын өнөөдөр хэлэлцэж байгаа асуудал 3 субъектэд үүрэг өгч байгаа юм.

**Нэгдүгээрт,** Монгол Улсын Засгийн газарт үүрэг өгч байгаа.

**Хоёрдугаарт,** Монголбанканд үүрэг өгч байгаа.

**Гуравдугаарт,** Санхүүгийн зохицуулах хороонд үүрэг өгч байгаа.

Тэгээд энэ ажлын дэд хэсэгт уг нь аль аль субъектийн гишүүд орсон байх ёстой.

Өнөөдөр энд аль аль субъектийн төлөөлөл ирээд хамт хариулт өгөөд сууж байх ёстой юм. Тэгээд ялангуяа банк бустай холбоотой асуудал Санхүүгийн

зохицуулах хорооноос үнэхээр арга хэмжээ авах ёстой.

Одоо ерөөсөө хүмүүсийн ярьж байгаагаар дандаа Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллүүд нэг банк бустай холбоотой болчихсон, хамааралтай болчихсон.

Тэгээд арилжааны банктайгаа бүр нийлээд тэгээд ерөөсөө мөнгө хүүлээд байж байдаг ийм асуудал яригдаж байгаа.

Тэгэхээр энэ үндсэн чиглэлийг баталсны дараа бид зайлшгүй Санхүүгийн зохицуулах хороотой бүр тусгайлан уулзах шаардлагатай байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Яах юм? Нэмж хариулах юм уу? Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг нэмж хариулъя. 1 минутад багтаагаад хариулаарай.

**Ц.Цэрэнпунцаг:** Санхүүгийн зохицуулах хорооных нь дарга гадаадад томилолттой ажиллаж байгаа.

Дээрээс нь Банк бусын тухай хууль орж ирж байгаа. Б.Дэлгэрсайхан сайд аа.

Дараагийн долоо хоногос хэлэлцэнэ. Энэ дээр бид энэ асуудлуудаа сайн ярилцаж, энэ хуулийнхаа хэлэлцэх явцдаа энэ дээрээ сайхан тусгаад энэ хууль, эрх зүйн орчин дээр нь чамбай сайхан ажиллачихъя бүгдээрээ нийлээд. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Угаасаа ирэх долоо хоногт эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлнэ.

Эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлэхээр Та бүхэн Байнгын хороон дээрээ ярих үедээ Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох албан тушаалтнуудыг байлцуулаад гишүүдийг мэдээллээр хангаад энэ асуудлаа хэлэлцээрэй гэдгийг хэлье.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо санал хураалт явагдана. Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. гишүүд байраа эзэлье.

Байнгын хорооноос бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя.

1.Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.Доор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/ Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

1/Орон сууцын ипотекийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэн авах хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэх;

2/Орон сууцын ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт

эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэгш, хүртээмжтэй хуваарилах.”

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. Санал хураалт гишүүд ээ. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ горимын санал гаргая.

**Б.Бат-Эрдэнэ:** Би санал дэмжиж өгсөн. Эсрэг талд гарчихлаа. Энэ саналыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Санал хураалгаж өгнө үү.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийн гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Санал хураалт. Гишүүд ээ. /алх цохив/

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт хүчингүйд тооцлоо.

Үндсэн санал хураалтыг явуулъя. Саналын томьёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт. /алх цохив/

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын



томьёоллоор санал хураалт явуулъя.  
Санал хураалт гишүүд ээ. /алх цохив/

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа.

Гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийнхаа асуудалд орно.

---

**Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл**  
*/Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/*

---

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар дээрх тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалтад заасны дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хувилбарын төслийг бэлтгэсэн.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн



тухай танилцуулгыг бэлтгэн Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

**Л.Мөнхбаатар:** Ц.Сандаг-Очир гишүүнд баярлалаа.

Одоо санал хураалт явагдана шүү. Гишүүд байраа эзлээрэй.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Санал хураалт явуулъя. Гишүүд байраа эзэлье. Санал хураалт явуулахад бэлтгэе.

Д.Тогтохсүрэн дарга, Одонгийн Цогтгэрэл дарга хоёр гишүүдээ санал хураалтад оруулъя. Ирцээ бүрдүүлъя.

Санал хураалтыг явуулъя.

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт гишүүд ээ. /алх цохив/

52.5 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Зочин танилцуулъя.

“Алдарт эх” цахим нэгдлийн одонтой ээжүүдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс ажил амьдралд нь хамгийн сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе. /алга ташив/

Дараагийнхаа асуудалд орно.

---

**Гурав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд  
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**  
*/Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн,  
анхны хэлэлцүүлэг/*

---

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг байгаа.

Энэ асуудал дээр нэг зарчмын зөрүүтэй горимын санал гаргачихъя гэж бодож байна.

---

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр 1 дүгээр зүйлийн 19.3.6 дахь заалтад нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн холбогдох заалтыг эшилсэн ийм зохицуулалтуудыг оруулж ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийг шинэчлэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль гээд нэг тусдаа, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль гээд хоёр тусдаа хууль болгоод баталчихсан байгаа.

Энэ хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлээд хэрэгжих юм.

Тэгэхээр хугацаа нь болоогүй байгаа хуулиудыг эшилчихсэн зүйл байгаад байна.

Ийм учраас хуулийн зохицуулалтаа нийцүүлээд энэ хэлэлцүүлгийг дахин явуулах ийм шаардлага үүсээд байна. Дахин явуулах.

Яагаад гэвэл 2024 онд хэрэгжих хуулийг хэрэгжихээр эшилчихсэн байгаа учраас.

Ийм учраас хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай байна.

Хуулийн төслийг дахин явуулах шаардлагатай гэж Улсын Их Хурлын гишүүдийн олонх үзэх юм бол хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр хэлэлцүүлэхээр буцаах боломжтой байгаа.

Ийм учраас энэ хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт буцаая гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Үг хэлэх юм уу? Яах вэ, энэ анхны хэлэлцүүлэгт л буцаах гэж байна шүү дээ. Тийм ээ.

Байнгын хороогоороо л анхны хэлэлцүүлэг хийе гэж байгаа юм.

Юу юм байна. Энэ санал дээр үг байхгүй юм байна.

Яагаад гэвэл шууд санал хураалт нь явагдах юм байна шүү. Дэгээрээ.

Санал хураалт явуулах уу? Бэлэн үү?

Анхны хэлэлцүүлэг дахин явуулах шаардлагатай гэж үзэж байгаа.

Энэ агуулгаар санал хураалтыг явуулъя.

Гишүүддээ санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8 дахь хэсэгт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн бол хуулийн төслийг Байнгын хороонд буцаана гэсэн зохицуулалт байгаа.

Ингээд хуулийн төслийг Байнгын хороонд буцааж байна.

холбогдох Байнгын хороонд даалгаж байна.

Дахин хэлэлцээд чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж ирэхийг

Дараагийнхаа асуудалд орёе гишүүд ээ.

---

### Дөрөв. Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал

---

Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцье.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэв-Очирын Анужин гишүүн танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

**П.Анужин:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Э.Бат-Амгалан Монгол Ардын намын бүлгээс Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад Бямбасүрэнгийн Энх-Амгаланг Улсын Их Хуралд сонгогдон ажилласан

туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг нь харгалзан улируулан сонгохоор нэр дэвшүүлж байгаагаа танилцуулсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан нь 1979-1989 онд Говь-Алтай аймгийн 10 жилийн 2 дугаар дунд сургууль, 1989-1991 онд Зөвлөлт Холбоот Улсын Улсыг Аюулаас Хамгаалах Хорооны Академид олон улсын эрх зүйч, 1991-1995 онд Монгол Улсын Их Сургуулийн олон улсын харилцааны сургуулийг гадаад албаны ажилтан мэргэжлээр тус тус төгссөн бөгөөд гадаад албаны ажилтан, аюулгүй байдал судлаач мэргэжилтэй.

Б.Энх-Амгалан нь 1995-1999 онд Монгол Улсын Аюулгүй Байдлыг Хангах Ерөнхий газар тусгай албаны ажилтан, ахлах ажилтан, 1999-2003 онд “Ворлд Трэйнс” компанид гүйцэтгэх захирал, 2005-2016 онд “Мишээл групп” компанид ерөнхий захирал, 2008-2016 онд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, тэргүүлэгчээр тус тус ажилласан байна.

Б.Энх-Амгалан нь 2016-2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол, Оросын парламентын бүлгийн дэд дарга, Монгол, Хятадын

парламентын бүлгийн гишүүн, 2019-2020 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам тээврийн хөгжлийн сайд, 2020 оноос одоог хүртэл Монгол Улсын Их Хурлын гишүүнээр дахин сонгогдон ажиллаж байгаа.

Төрийн ажлын мэдлэг, туршлагатай болно.

Тэрээр Улсын Их Хурал дахь Монгол, Оросын парламентын бүлгийн дэд дарга, Монгол, Хятад, Монгол, Беларусь, Монгол, Герман, Монгол, Солонгос, Монгол, Японы парламентын бүлгийн гишүүн төдийгүй 2022 оноос Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, 2023 оны 10 дугаар сараас Улсын Их Хурал дахь Монгол, Лаосын парламентын бүлгийн даргаар тус тус ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны даргад нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангаас асуулт асууж, үг хэлээгүй болно.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгаланг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар улируулан сонгох саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** П.Анужин гишүүнд баярлалаа.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Гочоогийн Ганболд, Ц.Цэрэнпунцаг нарын гишүүд бэлэн байж байгаарай. Асуултад хариулна.

Одоо Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Төсвийн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын

мэдлэг, ур чадварыг харгалзан Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэн хэлэлцүүлээ.

Ганзоригийн Тэмүүлэн Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын харилцааны сургуулийг 2003 онд олон улсын харилцааны бакалавр, 2005 онд тус сургуульд олон улсын удирдлагын магистрын зэргийг тус тус хамгаалсан.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн 2006-2009 онд Ашигт малтмал, газрын тосны газрын Гэрээлтийн хэлтэст мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга 2009-2014 онд төрийн өмчит “Эрдэнэс Монгол” компанийн дэд захирал, 2013-2015 онд “Оюу Толгой” ХХК-д Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, 2014-2015 онд Уул уурхайн дэд сайд, 2015 оноос Нийгмийн Ардчилал Монголын залуучуудын холбооны Ерөнхийлөгч, 2016 оноос одоог хүртэл Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2022 оноос Төсвийн байнгын хорооны даргаар сонгогдон ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Төсвийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэнг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал,

дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

**Л.Мөнхбаатар:** Х.Булгантуяа гишүүнд баярлалаа.

Зочин танилцуулья.

Монгол, Солонгосын Политехникийн коллежийн багш, оюутнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил хөдөлмөр, сурлагад нь өндөр амжилт сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.17, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны дарга даргыг сонгох тухай асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Та бүхэнд танилцуулж байна.

Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт Байнгын хорооны даргыг Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээ сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно гэж заасны дагуу Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Пүрэв-Очирын Анужинг улируулан сонгох асуудлыг хэлэлцүүлээ.

Пүрэв-Очирын Анужин нь 1977 онд Улаанбаатар хотод төрсөн. Нөхөр 4 хүүхдийн хамт амьдардаг.

Гадаад албаны ажилтан, олон улсын эрх зүйч мэргэжилтэй.

1994 онд нийслэлийн 13 дугаар дунд сургуулийг, 2000 онд Монгол Улсын Их Сургуулийн дэргэдэх Олон улсын харилцааны дээд сургуулийг гадаад албаны ажилтан мэргэжлээр төгссөн.

1999 онд Япон Улсын Токиогийн Гадаад хэлний дээд сургуульд судлаач оюутнаар, 2000-2003 онд Япон улсын Соко их сургуульд олон улсын эрх зүйч мэргэжлээр магистрын зэрэг хамгаалсан.

2004-2010 онд Япон Улсын “Сейфти технологи” компанид Ази хариуцсан мэргэжилтэн, хуулийн зөвлөхөөр, 2010-2016 онд “Монгол кино пикчерс” компанийг үүсгэн байгуулж,

төслийн продюсероор, 2009 оноос Монгол Ардын намын Бага хурлын гишүүнээр, 2010-2016 онд Монгол Ардын намын дэргэдэх Нийгмийн Ардчилал Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны дэд Ерөнхийлөгч, Зүүн бүс хариуцсан нарийн бичгийн дарга, 2013-2016 онд Монгол Ардын намын Удирдах зөвлөлийн гишүүнээр тус тус сонгогдон ажилласан туршлагатай.

2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2022 оноос Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар сонгогдон ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай болон Гэр бүлийн тухай хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцүүлэх, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхдээ салбар дундын уялдаа холбоог хангахад анхаарч ажиллах нь зүйтэй талаар саналаа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэв-Очирын Анужинг Нийгмийн бодлогын байнгын хорооны даргад улируулан сонгох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны

санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

**Л.Мөнхбаатар:** Ц.Сандаг-Очир гишүүнд баярлалаа.

Гишүүд танхимдаа орж ирээрэй. Одоо санал хураалт явагдана. Үйлдвэржилтийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Жигжидийн Батжаргал танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

**Ж.Батжаргал:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Та бүхэнд танилцуулж байна.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Ж.Батжаргал нэр дэвшигчийн төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболдыг нэр дэвшүүлэн хэлэлцүүлээ.

Г.Ганболд 1975 онд Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумд төрсөн, 48 настай. Эхнэр 3 хүүхдийн хамт амьдардаг.

Радио, холбооны инженер, бараа судлаач мэргэжилтэй.

Тэрээр 1990 онд Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын дунд сургууль, 1993 онд Эдийн засгийн коллеж, 1999 онд Шинжлэх Ухаан, Техникийн Их сургуулийн Холбоо, мэдээллийн технологийн сургууль, 2008 онд Удирдлагын хөгжлийн академийг удирдлагын менежер мэргэжлээр тус тус төгссөн.

Г.Ганболд 1993-1996 онд “Төгс Агар” ХХК-д оператор, 1997-1998 онд Өвөрхангай аймгийн холбооны газарт, 2000-2004 онд “Скайтел” ХХК-д Өвөрхангай аймаг дахь салбарын захирал, 2004-2008 онд Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газарт хэлтсийн дарга, 2008-2012 онд “Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн захирал, 2012-2016 онд Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, 2016-2020 онд Өвөрхангай аймгийн Засаг дарга, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболдыг нэр дэвшүүлснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх санал нэгтгэйгээр дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,



Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Ж.Батжаргал даргад баярлалаа.

Одоо Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Та бүхэнд танилцуулж байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн нэр дэвшигчдийн төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Эдийн засгийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцагийг улируулан сонгохоор нэр дэвшүүлж хэлэлцүүлээ.

Цэдэндамбын Цэрэнпунцаг нь 1988 онд Завхан аймгийн Б.Элдэв-Очирын нэрэмжит 10 жилийн 1 дүгээр дунд сургууль, 1997 онд Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн Механик, инженерийн сургуулийг автомашин ашиглалтын инженер мэргэжлээр, 2013 онд Америкийн Нэгдсэн Улсад Доминикан Их Сургуульд Бизнесийн удирдлагын магистраа тус тус төгссөн.

Ц.Цэрэнпунцаг нь 1999 оноос “Жем Групп”-ийн үүсгэн байгуулагч, Ерөнхийлөгч, 2005-2010 онд “Жи Мобайл” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, 2008-2016 онд “Ди Ди Эш ТВ” ХХК-ийн үүсгэн байгуулагч, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, 2008 оноос “Жем Нэт” ХХК-ийн үүсгэн байгуулагч, 2013 оноос “Эс Би Эс” телевизийн үүсгэн байгуулагч, зөвлөх, 2018 оноос “Хужирт тур” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2022 оноос Эдийн засгийн байнгын хорооны даргаар сонгогдон ажиллаж байна.

Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцагийг Эдийн засгийн байнгын хорооны даргаар улируулан сонгохоор нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Ж.Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа.

Зочин танилцуулья.

Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Цэндийн Сандаг-Очир гишүүний урилгаар Налайх дүүргийн “Эрүүл, идэвхтэй амьдрал” клубийн гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил хөдөлмөрт нь өндөр амжилт, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх хүн байна уу? Байхгүй байна.

Одоо санал хураалтууд явуулна. Гишүүд байраа эзэлье. С.Чинзориг гишүүн яасан. Ер нь асуучихмаар хэд хэдэн Байнгын хорооны дарга байгаа биз дээ. Уг нь. Санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт явуулья.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Бямбасүрэнгийн Энх-Амгаланг улируулан сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалт. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалтыг явуулья.

Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Пүрэв-Очирын Анужинг улируулан сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. /алх цохив/

61.9 хувиар санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны даргаар Ганзоригийн Тэмүүлэнг улируулан сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалт. /алх цохив/

69.0 хувиар санал дэмжигдлээ.

Үйлдвэржилтийн байнгын хорооны даргаар Гочоогийн Ганболдыг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалт. /алх цохив/

69.0 хувиар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцагийг улируулан сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалт. /алх цохив/

69.0 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны даргаар сонгох саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох,

чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцлоо. /алх цохив/

Тогтоолын төсөл байна уу? Улсын Их Хурлын тогтоолыг танилцуулъя.

Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэг санал хураалтын дүн үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболдыг сонгосугай.

2.Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгаланг, Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Пүрэв-Очирын Анужинг, Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэнг, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцагийг тус тус улируулан сонгосугай.

3.Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшинг Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн байнгын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Эцсийн найруулгыг сонсонд тооцлоо.

Монгол Улсад парламентын ардчиллыг төлөвшүүлэх, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт заасан эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэх үйл үйл хэрэгт чухал хувь нэмэр оруулсан үйл явдал энэ долоо хоногт болж байна.

Монгол Улсын Их Хурал Олон Улсын Парламентын Холбоотой 2022 оны 8 дугаар сард байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд жендэрийн мэдрэмжтэй парламент болон хүний эрхийн мэдрэмжтэй парламентын өөрийн үнэлгээг энэ өдрүүдэд хийж байна.

Олон Улсын Парламентын Холбоо жендэрийн мэдрэмжийн өөрийн үнэлгээг сүүлийн 10 жилийн хугацаанд бусад улстай хамтран зохион байгуулаад байгаа.

Хүний эрхийн өөрийн үнэлгээ манай улстай хамтран анх удаагаа зохион байгуулж байгаа гэдгээрээ их онцлог байгаа юм.

Бид хүний эрх, жендэрийн асуудлаар юу хийсэн, юу хийх шаардлагатай байгааг хөндлөнгийн хараат бус мэргэшсэн олон улсын

шинжээчдийн багаар хийлгэж байгаагаараа парламентын нэн шинэ түүхийн анхдагч үйл явдал болж байгаа гэдгийг Та бүгддээ хэлье.

Энэ хуралдаан “Ж.Сүхбаатар” танхимд үргэлжлэн явагдаж байгаа.

Энэ хуралдаанд Улсын Их Хурлын гишүүд идэвхтэй оролцохыг хүсье.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Гишүүд Олон Улсын Парламентын Холбоотой хамтарсан хуралдаанд идэвхтэй оролцоорой.

*Хуралдаан 1 цаг 58 минут үргэлжилж, 12 цаг 14 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**

---